



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



МАЛЧДАД ЗОРИУЛСАН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ГАРЫН АВЛАГА



Улаанбаатар хот
2021 он

Энэхүү гарын авлагыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний “Ололт амжилт” ХХК боловсруулав.

МАЛЧДАД ЗОРИУЛСАН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ГАРЫН АВЛАГА

Боловсруулсан:

Н.Бат-Отгон /Удирдахуйн ухааны Докторант/

Н.Очирбат /Техникийн ухааны Докторант, Мэргэшсэн инженер/

Г.Бурмаа /Мэргэжлийн өвчин судлаач, их эмч/

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: С.Лхагвасүрэн

Зураач: С.Нандинцэцэг

Хянан тохиолдуулсан:

Ж.Цэвэлмаа /ХНХЯ-ны ХЭБХЗГ-ын ХАБЭА-н хөгжлийн хэлтсийн ахлах шинжээч/

Энэхүү гарын авлагыг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын “Эдийн засгийг төрөлжүүлж, хүртээмжтэй өсөлтийг хангах хүрээнд албан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл (MNG/18/01/RBS)”-ийн дэмжлэгтэйгээр боловсруулж, хэвлэв. Гарын авлагын агуулга, түүнд дурдсан аливаа жишээ, баримтад илэрхийлсэн үзэл бодлыг зохиогчид, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариуцах бөгөөд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын байр суурь, үзэл бодлыг илэрхийлэхгүй болно.

ТОВЧИЛСОН ҮГ

ААЗ – Аюулгүй ажиллагааны заавар

МШӨ – Мэргэжлээс шалтгаалсан өвчин

НБХХ - Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл

ТТ – Тоног төхөөрөмж

ХАБЭА – Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

ХНХЯ- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

ТАНИХ ТЭМДЭГ



Эрсдэлт хүчин зүйлс



Анхаарах зүйлс



Заавар



Зөвлөмж



Санамж

ГАРЧИГ

1. Мал аж ахуйтай холбоотой ХАБЭА-н
эрсдэлт хүчин зүйлс 6-27
2. Мал амьтантай харьцах үеийн болзошгүй осол,
гэмтлээс урьдчилан сэргийлэлт 28-47
3. Орчны эрс тэс температурын сөрөг нөлөө,
түүнээс урьдчилан сэргийлэлт 48-59
4. Байгаль, цаг уурын эрсдэлтэй нөхцөлд
ажиллах бэлэн байдал 60-77
5. Мал амьтнаас хүнд халдах өвчний урьдчилан
сэргийлэлт78-103
6. Анхны тусламж104-122

ӨМНӨХ ҮГ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-н талаарх төрийн бодлого нь хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй ажлын байрыг бий болгоход оршино. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 дугаар тушаалаар “ХАБЭА-н сургалт явуулах болон шалгалт авах журам”, “ХАБЭА-н сургалтын хөтөлбөр”-ийг шинэчлэн баталсан. Уг журамд мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй малчид өөрийгөө осол, гэмтэл, халдварт өвчнөөс хэрхэн хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар мэдлэг олгох тусгайлсан сургалтын хөтөлбөр, сэдвийг тодорхойлж өгсөн.

Албан бус секторт хөдөлмөр эрхлэгч иргэний ХАБЭА-н талаарх мэдлэг ойлголт сул, осол гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж чаддаггүй зэрэг нөхцөл байдал түгээмэл байдаг. Иймээс малчдад зориулсан ХАБЭА-н талаарх гарын авлага боловсруулан бэлтгэх хэрэгцээ шаардлага чухлаар тавигдаж, энэхүү гарын авлагад мал аж ахуй эрхлэх явцад учирч болзошгүй осол гэмтэл, эрсдэлт хүчин зүйлс, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн агуулгыг тусгалаа.

Малчдад зориулсан ХАБЭА-н гарын авлагыг боловсруулахдаа мал аж ахуй эрхлэгч иргэн, малчин өрхийн өдөр тутмын үйл ажиллагаанд суурилсан судалгаа хийж, гарын авлагын төслийг Завхан, Дундговь, Сүхбаатар аймгийн малчин өрхүүдэд танилцуулан туршиж, тэдний гаргасан санал, шүүмжийг хүлээн авч, ХАБЭА-н сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний “Ололт амжилт” ХХК-тай хамтран боловсруулав.

Энэхүү гарын авлагыг малчин иргэн, өрх бүр үйл ажиллагаандаа ашиглахын сацуу өөрийгөө болон бусдыг осол, гэмтэл, өвчлөлөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажилд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Малчдад зориулсан гарын авлагыг боловсруулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан байгууллага, иргэн, ажилтан, албан хаагч нарт талархал илэрхийлье.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

НЭГ. МАЛ АЖ АХУЙТАЙ ХОЛБООТОЙ ХАБЭА-Н ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС

ХАБЭА-н тухай хууль нь Монгол улсын нутаг дэвсгэр дээрх бүхий л аж ахуйн нэгж, байгууллагаас эхлээд хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, хоршоо нөхөрлөлийн гишүүд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар ял эдэлж байгаа хоригдлуудад хүртэл үйлчилдэг байна. Иймд хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, малчдын төдийгүй бүхий л салбар чиглэлүүдэд ХАБЭА-н талаарх мэдээлэл, зөвлөгөөг хүргэх хэрэгцээ, шаардлага үүссэн.

ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлсийн талаарх ойлголтын өмнө, аюулын талаарх ойлголтыг мэддэг байх нь чухал. ХАБЭА-н удирдлагын тогтолцооны стандартад “Аюул нь хүнийг гэмтгэх, эрүүл мэндэд нь хохирол учруулах, эсвэл эдгээр нь хосолсон байдлаар учруулах бодит аюул бүхий эх үүсгүүр, нөхцөл байдал буюу үйлдэл юм ” гэж тодорхойлсон байдаг. Малчид мал аж ахуй эрхлэх явцдаа төдийгүй өдөр тутмын гэр ахуйн үйл ажиллагаандаа ч эрүүл мэнд, амь насыг нь аюул, эрсдэлд оруулж болохуйц зүйлстэй байнга тулгардаг. Жишээ нь: эмнэг сургах үйлдэл нь эмнэг хангалаас унах, ойчих эрсдэл дагуулдгаараа аюултай. Ажлын байран дахь аюулыг төрлөөр нь дараах байдлаар ангилдаг.

АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛЫН ТӨРӨЛ					
Хими	Физик	Биологи	Сэтгэл зүй	Эргономик	Аюулгүй байдал
Химийн хортой, аюултай бодис (хатуу, шингэн, хийн төлөвтэй) будаг, лак, бензин, хүчил, уусгагч гэх мэт.	Цацраг туяа соронзон орон, өндөр даралт, вакум орчин, дуу чимээ, халуун, хүйтэн Температур гэх мэт.	Ургамал, хүн, амьтан, шавьж, бактери, вирус, мөөгөнцөр, хөгц, цус ба бусад шингэн, ялгадас гэх мэт.	Ажлын хэт ачаалал, стресс, хүчирхийлэл, бэлгийн дарамт гэх мэт.	Ажлын байрыг буруу тохируулах, олон давтагдах хөдөлгөөн, хэт хүчлэх, мушгиа, сунах байрлал, хөдөлгөөн гэх мэт.	Гулсах, бүдрэх, ил эргэлдэх эд ангитай тоног төхөөрөмж, өндөрт ажиллах, ил гарсан, шалбарсан цахилгааны утас гэх мэт.

Аюулын төрөл ба өртөлтөөс хамааран тэдгээрийн үйлчлэл нь харилцан адилгүй байдаг. Тухайлбал эргономикийн аюулд удаан хугацаанд өртсөнөөр яваандаа Мэргэжлээс шалтгаалсан өвчин (МШӨ) үүсдэг бол, аюулгүй байдлын аюулд өртсөн даруйдаа шууд гэмтэл, бэртэл авдаг байна.

Аюулыг мөн арилгаж болдог, болдоггүй гэж ангилдаг. Арилгаж болдоггүй аюулаас үүдэх эрсдэлийг удирдах хэрэгтэй болно. Жишээ нь: өнөөдөр дэлхий нийтэд нүүрлээд буй корона вируст цар тахлын аюулыг арилгаж чадахгүй байгаа тул халдвар авах, өвчлөх эрсдэлийг маск зүүх, гараа ариутгах, зай барих байдлаар удирдаж буй ойлголт юм.

Мал аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой нийтлэг тохиолддог ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс ба тэдгээрээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг доорх бүтцийн дагуу танилцуулна.

1. Мал аж ахуйтай холбоотой үйл ажиллагаанууд



2. ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

3. Урьдчилан сэргийлэх зөвлөмж









ХАШАА ХОРОО БАРИХ, ЗАСВАРЛАХ



ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- △ Мод, чулуу хөл гар дээрээ алдах, унагах
- △ Гар, биед өргөс орох, хурц үзүүртэй эд зүйлст эсгэх, урах
- △ Нүдэнд тоос, шороо орох
- △ Алх, лантуу, хүрз, жоотуунд цохиулах
- △ Хадаастай банз, модон дээр гишгэх
- △ Мушгирсан, сунасан, бөхийсэн байрлалаас ажиллах, хүнд эд зүйлс өргөх, зөөх ба эдгээрийг олон дахин хийх, улмаар хүзүү нурууны шохойжилт үүсэх
- △ Хашаа, хороо салхинд нурах, ойчих ба түүнд дарагдах, цохиулах

Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Хүнд эд зүйлсийг хамтарч өргөх
-  Ажлын хувцас, бээлий өмсөх
-  Нүдний шил зүүх
-  Алх, лантуу, хүрз, жоотуугаар ажил хийхдээ хоорондын зайг баримтлах, далайлтын зайд хүн ба эд зүйлс байгаа эсэхийг үргэлж нягтлах
-  Явах, гишгэх хэсгээ тогтмол харах, хатуу ултай гутал өмсөх
-  Аль болох өөрт эвтэй байрлалаас ажиллах
-  Хашаа, хорооны бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах, нурж болзошгүй хэсгийг засварлах
-  Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж (ТТ)-ийг хүүхдээс хол байлгах








МОТОЦИКЛ УНАХ, ЖОЛООДОХ



ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- △ Мотоциклоос унах, ойчих
- △ Дугуй буудах, хагарах
- △ Шарвах, гулгах, харайлгах
- △ Гуу жалга, эрэг уруу унах
- △ Хүн, амьтан, эд зүйлс мөргөх, шүргэх, дайрах

Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Хурдаа тохируулж явах
-  Дугуйг хэт их хийлэхгүй байх (ялангуяа урд дугуйг)
-  Жолоо барих үедээ согтууруулах ундаа, мансууруулах төрлийн зүйлс хэрэглэхгүй байх
-  Мотоцикл жолоодох эрхтэй байх, сургалтанд хамрагдсан байх
-  Техникийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах (гэрэлтүүлэг, толь, тормоз гм).
-  Хөдөлгөөнд оролцохдоо хүн, амьтан, эд зүйлсээс зай барих
-  Цаг агаарын онцгой нөхцөл байдалд аль болох замд гарахгүй байх (цасан болон шороон шуурга, үер ус, аянга цахилгаан)









МАШИН, МОТОЦИКЛ ЗАСАХ, ҮЗЛЭГ ХИЙХ



ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- △ Машин, мотоцикл хяналтгүй өнхрөх, хүн амьтан, эд зүйлс мөргөх, шүргэх, дайрах
- △ Машин, мотоциклд дарагдах, хавчуулагдах, сэнс дамар болон эргэлдэх эд ангид орооцолдох
- △ Түлхүүр багаж сугарч гар, биеэ цохих, толгойгоо цохих
- △ Халуун мотор, эд анги, тос шингэнд түлэгдэх
- △ Машины эд ангиудыг салгах, өргөх, буулгах үед гар хөлөө хавчуулах, дарагдах

Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Тэгш, урвуу бүхий л газар машиныг байрлуулахдаа гар кардан татах, дугуйнд ивүүр хийх
-  Машин, мотоциклийг унтраасны дараа засвар, үйлчилгээ хийх бөгөөд асаах түлхүүр зөвхөн засвар хийж буй хүнд байх
-  Тухайн эд ангид таарсан багаж хэрэгслийг ашиглах
-  Уранхай ноорхой, оосор бүч ихтэй хувцас өмсөхгүй байх
-  Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл (НБХХ) хэрэглэх
-  Халсан мотор болон бусад эд ангиудыг хөрсөний дараа үзлэг шалгалт хийх, засварлах
-  Аль болох ганцаараа ажиллахгүй байх
-  Овор ихтэй, хүнд эд ангиудыг өргөхдөө таль ашиглах, эсвэл найдвартай оосорлож олуулаа хамтарч өргөх, буулгах

ТҮЛШ БЭЛТГЭХ (МОД, НҮҮРС ХАГАЛАХ, ХӨРӨӨДӨХ)



⚠ ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- △ Мод, нүүрсний үртэс нүүр ам, нүдрүү үсрэх
- △ Сүх, алх, лантуунд цохиулах ба тэдгээрийн иш нь мултрах
- △ Хөрөөний ирэнд гар, биеэ зүсэх
- △ Хөрөөдсөн мод, хагалж буй нүүрс хөл, гар дээр унах
- △ Хүнд, том овортой мод, нүүрс өргөх, зөөхөд нуруу гэмтэх

📖 Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Хамгаалалтын нүдний шил, масктай ажиллах (болж өгвөл нүүрний хаалттай ажиллах)
- 📖 Хоёр буюу түүнээс дээш хүн нэг дор ажиллах тохиолдолд хоорондоо зайтай ажиллах
- 📖 Сүх, лантууны далайлтын зайд хүн, эд зүйлс байгаа эсэхийг нягтлах, тэдгээрийн ишний түгжээ, найдвартай байдлыг тогтмол шалгах
- 📖 Хөрөөний ирэнд нүцгэн гараар хүрэхгүй байх, зөөхдөө ирний эсрэг талаас нь барьж явах
- 📖 Хүнд, том мод, нүүрсийг техник ашиглан өргөх, зөөх (боломжгүй бол юмаар хөших, олуулаа хамтарч өргөх, бод мал ашиглах)

ХАДЛАН ТЭЖЭЭЛ БЭЛТГЭХ, УРГАЦ ХУРААХ



⚠ ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- ⚠ Мушгирсан, сунасан, бөхийсэн байрлалтай ажиллах, хүнд эд зүйлс өргөх, зөөх ба эдгээрийг олон дахин хийх, хүзүү нуруугаар хөших, гэмтэх
- ⚠ Анжис, хадуур, хүрзэнд гар, бие цохигдох
- ⚠ Тоос, шороогоор амьсгалах, нүдрүү орох
- ⚠ Шуудайтай, овор ихтэй хүнд өвс, ногоо өргөх, зөөх, нуруу болон тулгуур эрхтэнээ гэмтээх

📖 Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Аль болох биед эвтэй байрлалаар амралт завсарлагатай ажиллах
- 📖 Хүнд, овор ихтэй эд зүйлсийг хамгарч өргөх, эсвэл техник ашиглах
- 📖 Хоёр буюу түүнээс дээш хүн зэрэг өвс хадахдаа хоорондоо зайтай ажиллах
- 📖 Амьсгал хамгаалах маск, нүдний шил, ажлын хувцас НБХХ-тэй ажиллах
- 📖 Аливаа эд зүйлсийг өргөхдөө зөв техникээр өргөх (доош суугаад нуруу цэх байрлалаас өргөх)

УС ЗӨӨХ



⚠ ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- ⚠ Хэт том овор хэмжээтэй саваар ус зөөх, нуруу болон тулгуур эрхтэнээ гэмтээх
- ⚠ Савтай усыг хөл, гар дээрээ алдах, унагах, асгах

📖 Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Том хүн болон хүүхдэд тус бүр тохирсон овор хэмжээтэй савыг ашиглах, бусадтай хамтарч зөөх
- 📖 Хэт холоос ус зөөх тохиолдолд бод мал, машин, мотоцикл ашиглах бөгөөд тэдгээрийн татлагыг сайтар бэхлэх, явах замдаа үе үе шалгах
- 📖 Савтай усыг гараар зөөхдөө нуруу цэх байрлалтай явах ба үе үе амрах
- 📖 Гараар зөөх ачааны жин 2 талдаа тэнцүү байх






МАЛ УСЛАХ



ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- △ Худгийн ам уруу хөл алдаж унах, ойчих, хальтрах, бүдрэх, тээглэх
- △ Ховоо хэт том байх, амралтгүй ус татах, нуруу хөших, гэмтэх
- △ Ховооны иш, оосорт гараа урах, шалбалах, орооцолдож унах

Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Харгалзах хүнтэй хамт малаа услах, худгийн аман дээр аль болох ус асгахгүй байх
-  Ховоо нь том, жижиг сонголттой байх, ус татахдаа бусад хүнтэй ээлжлэн амралттай татах
-  Ховооны иш, оосрыг хүний гар гэмтээхээргүй материалаар хийх
-  Ажлын бээлий хэрэглэх (резинэн алгатай хальтардаггүй бээлий)
-  Мал услаж дууссаны дараа худгийн амыг таглах, хаах

БУУЦ, ХӨРЗӨН ХОВХЛОХ



⚠ ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- △ Бууц хөрзөнг хөл, гар дээрээ алдах, унагах
- △ Гарт өргөс орох
- △ Нүд, хамарт нарийн ширхэгтэй тоос, шороо орох, амьсгалах
- △ Бууц, хөрзөн шатах, гал түймэр гарах
- △ Хүрз, жоотуунд цохиулах
- △ Хэт хүчилсэн, мушгирсан, сунасан, бөхийсэн байрлалтай удаан хугацаагаар олон дахин ажиллах, хүзүү нуруу хөших

📖 Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Хүнд эд зүйлсийг хамтарч өргөх эсвэл машин техник ашиглах
- 📖 Ажлын хувцас, нүдний шил, маск, бээлий гэх мэт НБХХ өмсөх, зүүх
- 📖 Бууц, хөрзөнгийн ойролцоо ил гал, оч гаргахгүй байх, тамхи тагахгүй байх
- 📖 Хүрз, жоотуугаар ажиллахдаа хүн хоорондын зайг баримтлах, далайлтын зайд хүн ба эд зүйлс байгаа эсэхийг нягтлах
- 📖 Аль болох өөрт эвтэй байрлалаар, амралттай ажиллах

АРГАЛ, ХОМООЛ ТҮҮХ



⚠ ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- △ Том арагаар, их хэмжээний, хүнд (нойтон) аргал хомоолыг удаан хугацаагаар үүрэх, хол газар явах, нуруу, хүзүү хөших
- △ Хэлтгий газар хөл алдах, хад чулуунд тээглэх, бүдрэх, ойчих

📖 Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Боломжтой бол арагны хоёр талд оосор хийгээд хамтарч өргөх, зөөх
- 📖 Хол газар ганцаараа үүрч явах тохиолдолд үе үе амрах, дал мөр нухахааргүй зузаан хувцас өмсөх эсвэл жийрэг, зөөлөвч хийх
- 📖 Боломжтой бол аргал түүхээр явахдаа тэвштэй машин ашиглах
- 📖 Замын бартаа саадыг сайтар анзаарч, анхаарал болгоомжтой явах

ХАШАА САРАВЧИН ДЭЭР АЖИЛЛАХ, ӨВС ХУРААХ



⚠ ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- ⚠ Хашаа, саравчин дээрээс хөл алдаж унах, ойчих, үсрэх
- ⚠ Хүнд, овор хэмжээ том өвс тэжээлийг өргөх, зөөх, бүдэрч унах, нуруугаа гэмтээх
- ⚠ Гарт өргөс орох, зоогдох
- ⚠ Хуучирсан, хагарч цуурсан, нимгэн банз, саравч нурж унах, цөмрөх, хөл гараа гэмтээх

📖 Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Саравчин дээр гарах, буухдаа зориулалтын шат ашиглах ба шатан дээр гурван цэгийн тулгуур буюу хоёр хөл нэг гар, эсвэл хоёр гар нэг хөл гэсэн зарчмыг баримтлан шат талруугаа харж буух
- 📖 Хүнд, овор ихтэй өвс тэжээлийг хамтарч өргөх, зөв техникээр өргөх (доош суугаад нуруу цэх байрлалаас өргөх)
- 📖 Хашаа саравчийг битүүмжлэх, сайжруулах, засвар хийх
- 📖 Ажлын хувцас, НБХХ өмсөх
- 📖 Салхи шуургатай үед хашаа саравчин дээр гарахгүй байх

ТОГОО НЭРЭХ, СҮҮ ЦАГАА БУЦАЛГАХ




⚠ ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- ⚠ Халуун уур, шингэнд түлэгдэх
- ⚠ Хөөрүүлэх, тогоо давж асгарах

📖 Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Гал дээр буцалж буй аливаа зүйлийн дээгүүр эд зүйлс дамжуулахгүй байх
- 📖 Тогооны таг авах үед тогооны дээд хэсэг болон ууранд ойртохгүй байх
- 📖 Буцалгах гэж буй ус, сүү, цагааг тогоонд хэт дүүрэн хийхгүй байх
- 📖 Ханцуйтай дээл, хувцас өмсөх
- 📖 Халуун тогоотой зүйлийг зуухнаас буулгахдаа халалт тусгаарлагч бүхий материалтай жийргэвчийг ашиглах
- 📖 Том овор хэмжээтэй тогоо дүүрэн сүү цагааг хамтарч өргөх, буулгах






БУУ, СУМТАЙ ХАРЬЦАХ, ХАДГАЛАХ




ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- △ Буу, сумыг хүүхэд багачууд, залуучууд сонирхож гал алдах
- △ Сум тэсрэх, дэлбэрэх

Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Буу, сум хоёрыг тус тусад нь хүүхэд багачуудын нүднээс далд, цоожтой авдар саванд хадгалах
-  Сумыг нарны шууд тусгал болон халалт үүсгэдэг эд зүйлсээс хол, цоожтой битүү саванд хадгалах
-  Буу, сум хадгалах авдар, савыг байнга цоожлох бөгөөд түлхүүрийг нь бууны эзэн биедээ авч явах эсвэл найдвартай газар нуух
-  Бууг морин дээр авч явахдаа амыг нь газар руу харуулж үүрэх
-  Галт зэвсэг эзэмших эрхтэй байх, холбогдох байгууллагаас нь сургалт, зөвлөгөө авсан байх

ГАЛ ТҮЛЭХ



⚠ ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- ⚠ Зуух, яндангийн цоорхой хэсгээр утаа униар гарах, угаартах
- ⚠ Галыг сэтгэж байхад зуухны амнаас цог унах, эд зүйлс түлэх, түлэгдэх
- ⚠ Халуун зууханд хүүхэд багачууд түлэгдэх

📖 Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Зуух болон яндангийн бүрэн бүтэн байдлыг сайтар хангах
- 📖 Яндангийн залгаасыг зөв хийх, тогтмол давтамжтай хөөлөх
- 📖 Зуухны амны доод хэсэгт галд тэсвэртэй материалаар хийсэн тосгуур суурилуулах
- 📖 Бага насны хүүхдийг халуун зуухнаас хол байлгах, болж өгвөл хаалт, бусад тоноглолыг хийх
- 📖 Зуух руу элдэв төрлийн битүү сав, шингэн хийхгүй байх
- 📖 Үнсийг тогтмол гадагшлуулах бөгөөд ил задгай газар асгахгүйгээр зориулалтын битүү, төмөр саванд хийх

МАШИНААР ОТОР, НҮҮДЭЛ ХИЙХ



ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- △ Зам тээврийн осолд орох, хүн амьтан, эд зүйлс мөргөх, шүргэх, дайрах
- △ Гуу жалга, эрэг руу унах, ойчих
- △ Ачсан болон ачиж буй ачаа, бараа унах, ойчих, хүн амьтан цохих, даргах
- △ Машин техник, отрын вагончиг хяналтгүй өнхрөх
- △ Чиргүүлний гар мултрах, хугарах

Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Замын хөдөлгөөний дүрмийг чанд мөрдөх, жолооч нь тухайн тээврийн хэрэгсэлд тохирох ангилалын үнэмлэхтэй байх
- 📖 Харуй бүрэнхий, шөнө дөлөөр отор, нүүдэл хийхдээ машин техникийн гэрэлтүүлгийн бүрэн бүтэн байдлыг хангах ба хурдаа тохируулж явах
- 📖 Ачаа барааг хамтарч өргөх, зөөх ба тэдгээрийг сайтар бэхлэх, явах замдаа үе үе шалгах
- 📖 Дугуйтай машин техник, хэрэгслүүдийг зогсоох, байрлуулахдаа гар кардан татах, дугуйнд тогтмол ивүүр хийх
- 📖 Чиргүүлний гарыг чирэгчээс сайтар бэхлэх бөгөөд нүүдлийн явцад үе үе шалгах
- 📖 Жолооны хүрдийг нэг тийш нь хэт, огцом эргүүлэхгүй байх
- 📖 Машинаа хөдөлгөхөөс өмнө хажуу тал болон доогуур нь хүн амьтан, эд зүйлс байгаа эсэхийг тогтмол шалгах, дуут дохио өгөх
- 📖 Согтууруулах ундаа хэрэглэсэн, нойргүй, ядарсан үедээ автомашин жолоодохгүй байх

МАЛЫН ЭРЭЛД ЯВАХ



⚠ ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- △ Өлсөж ундаасах, цангах
- △ Төөрөх, зүг чигээ алдах
- △ Унасан морь нь ядрах сульдах
- △ Аливаа зүйлээс морь нь үргэх, хулгана, зурмын нүхэнд бүдрэх, мориноос унах, ойчих

📖 Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Олон хоногоор явах тохиолдолд хоол хүнсээ нөөцлөж явах
- 📖 Айл бараадаж явах, хоноглох
- 📖 Холбоо барих утас, дуран, луужинтай явах, малын эрлийн талаар ар гэрийнхэндээ мэдээлж байх
- 📖 Хос морьтой явах ба ээлжлэн унах
- 📖 Харанхуй шөнө аль болох явахгүй байх
- 📖 Тухайн улирлын нөхцөлд байдалд тохирсон нөөц хувцас, хэрэглэлтэй явах

МАЛ ХАРИУЛАХ



⚠ ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- △ Могой, хорхой шавжинд хатгуулах
- △ Халуунд нарших, хүйтэнд даарч хөрөх, бээрэх
- △ Хадан цохио, эрэг, гуу жалга, гол ус уруу унах, ойчих, живэх
- △ Өргөстэй, үзүүртэй өвс ургамалд гар болон биеийн ил хэсгээ зүсэх гэмтээх

📖 Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Могой болон хорхой шавж ихтэй газар суухгүй, хэвтэхгүй байх
- 📖 Халуунд бүрх малгай, чийгтэй алчууртай малд явах бөгөөд уух зүйлсийг нөөцлөн авч явах
- 📖 Хүйтэнд дулаан хувцасаа өмсөх, явганаар мал хариулахдаа хэт хол явахгүй байх
- 📖 Мал бэлчээх, хариулах газраа зөв сонгох, туршлагатай хүнээс асуух
- 📖 Биеийн бүхий л хэсгийг бүрхсэн битүү, зузаан гутал, хувцастай малд явах, хариулах хэрэгтэй

ГЭР БАРИХ




⚠ ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- ⚠ Унь, тооно толгой, бие дээр унах, ойчих, цохиулах
- ⚠ Хүнд эд зүйлс өргөх, нуруугаа гэмтээх
- ⚠ Гэр дээр ажиллаж байгаад унах, цөмрөх, гулсаж ойчих

📖 Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Гэрийн тооно, баганыг унь өлгөж дуустал хөдөлгөөнгүй барих (болж өгвөл 2 хүн түшэх)
- 📖 Унь, тооно унаж болзошгүй гэрийн дотор талаар аль болох явахгүй, зогсохгүй байх
- 📖 Хүнд туурга болон бусад эд зүйлсийг хамтарч өргөх, зөөх
- 📖 Гэр дээр гарах тохиолдолд зөөврийн шат ашиглах
- 📖 Гэр дээр жин ихтэй хүн гаргахгүй байх, нарийн уньтай хэсгээр явахгүй байх

ХУДАГ ГАРГАХ, ЗАСВАРЛАХ



⚠ ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- ⚠ Худгийн ам руу унах, ойчих
- ⚠ Мод, чулуу хөл гар, бие дээрээ алдах, унагах, дарагдах, хавчуулагдах
- ⚠ Хүрз, жоотуунд цохиулах, иш нь мултрах
- ⚠ Мушгирсан, сунасан, бөхийсэн байрлалаас ажиллах, хүнд эд зүйлс өргөх, зөөх ба эдгээрийг олон дахин хийх, улмаар хүзүү нуруугаа гэмтээх
- ⚠ Нүдэнд тоос, шороо орох
- ⚠ Хүчилтөрөгчийн дутагдалд орох, ухаан алдах

📖 Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Харгалзах хүнтэй хамтарч ажиллах, олс, бүс, бэхэлгээ хэрэглэх
- 📖 Хүнд, овор хэмжээ ихтэй эд зүйлсийг хамтарч өргөх, техник эсвэл бод мал ашиглах
- 📖 Аливаа өргөж буй эд зүйлсийн дор хүн байлгахгүй байх
- 📖 Хүрз, жоотууны далайлтын зайд хүн ба эд зүйлс байгаа эсэхийг нягталж, тэдгээрийн ишний түгжээ, найдвартай байдлыг тогтмол шалгах
- 📖 Аль болох өөрт эвтэй байрлалаас ажиллах
- 📖 Тухайн нөхцөл байдалд тохирсон ажлын хувцас, НБХХ хэрэглэх

ХИМИЙН БОДИС БҮХИЙ ТҮҮХИЙ ЭД МАТЕРИАЛЫН ХЭРЭГЛЭЭ, ХАДГАЛАЛТ




⚠ ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- ⚠ Укус, белизна, будаг, лак, угаалгын шингэн гэх мэт химийн найрлага бүхий эд зүйлсийг хүүхдүүд санамсаргүй уух, залгих, арьс салстаа түлэх, гэмтээх
- ⚠ Аккумуляторын шингэнд түлэгдэх
- ⚠ Бензин, тос, маслыг андуурах, халаах, гал гарах, тэсэрч дэлбэрэх

📖 Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Химийн найрлага бүхий материал, түүхий эдийг хүүхдийн нүднээс далд, цоожтой саванд хийх, хадгалах
- 📖 Гэрт байлгах шаардлагагүй эд материалыг тусад нь ялган илүү гэр болон амбаар саванд хийх
- 📖 Хаяг шошгогүй саванд юу нь мэдэгдэхгүй эд зүйлс хийхгүй байх, хэрвээ хийх тохиолдолд тэмдэг тэмдэглэгээ сайтар хийх, нэрийг нь бичих, бөглөө таглааг нь найдвартай хийж шалгах
- 📖 Аккумуляторын гадуур хайрцаг сав хийх, битүүмжлэх
- 📖 Угаар, ууршилт явагддаг эд зүйлстэй орчинд ил гал, оч гаргахгүй, тамхи татахгүй байх

ХИЙ(ГАЗ)-Н БАЛЛОН, АСААГУУРТАЙ ХАРЬЦАХ



⚠ ХАБЭА-н эрсдэлт хүчин зүйлс

- ⚠ Баллон, асаагуур тэсэрч дэлбэрэх
- ⚠ Хий алдагдах
- ⚠ Гал гарах

📖 Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Баллоны хаалт, хоолой, шлангаас хий алдагдаж байгаа эсэхийг савангийн хөөс, хий мэдрэгч зэргээр шалгах
- 📖 Хоолой, шланг нь хуучирч элэгдээгүй, хатуураагүй, язраагүй, хавагнаагүй байх
- 📖 Хийн асаагуур, баллоныг ил гал, зуухнаас хол зайд, нар шууд тусахааргүй газарт байрлуулах
- 📖 Баллоныг тэгш бус гадаргуу дээр байрлуулахгүй байх
- 📖 Баллоныг хийн төхөөрөмжөөс 1 м-ээс багагүй, зуухнаас 2 м-ээс багагүй зайд байрлуулах
- 📖 Гэр дотор байрлуулах тохиолдолд агааржуулалт сайн байх (хаяа шуусан, тооно онгорхой гэх мэт)
- 📖 Баллоныг ажиллаж байх үед нь засвар хийх, хатуу биетээр цохиж доргиож болохгүй.
- 📖 Үйлдвэрлэгчийн заавартай сайтар танилцаж мөрдөх
- 📖 Баллоныг тэвштэй машин дээр босоо байрлалтай тээвэрлэх
- 📖 Баллон болон плиткаг холбосон хоолой, шлангийг нугалах, дарагдах, мушгих, зүсэгдэх, халаах зэргээс болгоомжлох
- 📖 Хий алдагдсан, баллоныг сольж залгах үед ил гал гаргах, тамхи татахыг хориглоно.
- 📖 Хийн төхөөрөмжийг ажиллаж байх үед хараа хяналтгүй орхиж болохгүй



Малчид та бүхэн мал аж ахуйтай холбоотой хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлт хүчин зүйлс ба урьдчилан сэргийлэх зөвлөмжийн талаар тодорхой ойлголт, мэдлэгтэй байж болох ч, тэдгээрийг өдөр тутмынхаа үйл ажиллагаанд мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах нь хамгаас чухал юм. Өөрөөр хэлбэл эрсдэлийг удирдана гэдэг нь урьдчилан сэргийлэх зөвлөмжийг нэг бүрчлэн дагаж мөрдөхийг хэлдэг.

ХОЁР. МАЛ АМЬТАНТАЙ ХАРЬЦАХ ҮЕИЙН БОЛЗОШГҮЙ ОСОЛ, ГЭМТЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ


Аливаа осол, гэмтлийн дараачийн үр дагавар нь хүний бие махбодь болон өрх гэрийн эдийн засагт ямагт сөргөөр нөлөөлж байдаг. Жишээ нь, нэгэн малчин мориноос унаад хөл, нуруугаа гэмтээлээ гэж бодъё. Энэ тохиолдолд эрүүл мэндийн байгууллага, эмчид үзүүлэн рентген зураг авахуулах, эм тан бичиж өгсний дагуу тэдгээрийг худалдаж авах, тодорхой хугацаанд хөдөлгөөнгүй гам барих гэх мэтээр мөнгө санхүү, ажлын бүтээмж, цаг хугацаагаар хохирч байдаг. Цаашлаад амь насаа алдах, үүрдийн тахир дутуу болохыг ч үгүйсгэх аргагүй юм. Учир нь мал амьтантай харьцаж ажиллах нь эрсдэлтэй бөгөөд тийм ч амархан ажил биш юм. Тухайлбал эмнэг сургах, бод мал төхөөрөх, морь тэмээ унах, ачаа бараа зөөх, нүүдэллэх гэх мэт тоочоод баршгүй олон ажлууд байдаг.

Хүн бүр л өдөр тутамдаа хийдэг энгийн ажил мэт боловч хайхрамж болгоомжгүй хандсаны улмаас олон хүн бэртэж гэмтэж, осолдож, эрүүл мэндээрээ хохирч байгааг бид төдийлөн анзаардаггүй. Иймд болзошгүй осол, гэмтлийн талаар, мөн тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга зам ба зөвлөмжийн талаар малчдад сануулах, таниулах нь энэхүү гарын авлагын бас нэгэн зорилго юм.

Мориноос унах



Дөрөөнд чирэгдэх




Үхэрт мөргүүлэх



Тэмээнд тийрүүлэх




Малд хазуулах




Моринд өшиглүүлэх



Малд хөлөө гишгүүлэх



Эвэртэй малд мөргүүлэх









Нийтлэг шалтгаан ба урьдчилан сэргийлэлт

Осол, гэмтлийн шалтгаан

- △ Унаж буй морь, тэмээ нь амьтны нүхэнд бүдрэх, цөмрөх
- △ Хог болон аливаа эд зүйлсээс үргэх, бусгах, туйлах
- △ Хангал, догшин морь малтай харьцах, унах, саах
- △ Эх мал төлөө харамлах
- △ Малтай буруу харьцах, зодох
- △ Морь малаас унах, ойчих үед томдсон дөрөөнд хөл шурган орох
- △ Чөдөр, тушаа хийгээгүй байх
- △ Олом, жирэм чангалах үед
- △ Малтай харьцахад тохирсон гутал, хувцасгүй байх

Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Амьтны нүх ихтэй, хэт огцом налуу, мал үргэх эд зүйлс (хог гм), цөмөрч болзошгүй хөрстэй газраар аль болох явахгүй байх
-  Дөрөөнд хөл шурган орохоос хамгаалсан хоригтой байх эсвэл гутал, дөрөө хоёр таарсан байх
-  Олом жирэм чангалах болон малд мордохдоо, малын амыг цааш нь дарж татаж байгаад чангалах, мордох
-  Эх малыг саахдаа чөдөр, тушаа хэрэглэх эсвэл төлийг нь ойр байлгах
-  Мал амьтантай харьцахад тохирсон ажлын хувцас, гутал, НБХХ-тэй байх
-  Аливаа малтай аядуу зөөлөн харьцах ба бага насанд нь сайн уях, номхоруулах

Мал амьтантай харьцахдаа эцэг өвгөдөөс сургаж ирсэн уламжлалт арга барилаар ажиллахаас гадна орчин үеийн техник хэрэгсэл, арга барилыг судлан хэрэгжүүлэх хэрэгтэй. Тухайлбал барилга, уул уурхайд л хэрэглэдэг гэж боддог хоншоор хэсэгтээ аюулгүйн төмөртэй ажлын гутлыг бод малд гишгүүлж хөлөндөө гэмтэл, бэртэл авахаас урьдчилан сэргийлж өмсөж болох юм. Мөн хашаа хороо засварлах, тасдагч ажиллуулах үед нүүрний тунгалаг хамгаалалт хэрэглэх, өтөг бууц хэрзэн ховхлоход нарийн ширхэгтэй тоосноос хамгаалах маск, хошуувчийг хэрэглэж болно.

Мал амьтантай харьцах үед тохиолдож болзошгүй нийтлэг осол, гэмтлүүд болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг дараах байдлаар харуулав.





ЯМАА САМНАХ



Болзошгүй осол, гэмтэл

- △ Самны иш болон үзүүрт гараа ураг, цохих, шалбаргах
- △ Ямааны эвэрт толгой, нүүр, биеэ сэжлүүлэх

Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Ямааг аль болох хөдөлгөөнгүй хүлэх ба сам барьсан гараас нөгөө гараа зайтай байлгаж самнах
-  Самны ишийг гар гэмтээхээргүй материалаар хийсэн байх
-  Ажлын бээлий болон битүү хувцас өмсөх, хачигт хазуулахаас болгоомжлох
-  Ямааны толгой, эвэрт ойр байрлаж ажиллахдаа эврийг хөдөлгөөнгүй дарж самнах






МАЛ СААХ



Болзошгүй осол, гэмтэл

- △ Малд өшиглүүлэх, тийрүүлэх, хазуулах, мөргүүлэх
- △ Малаас хүнд халдах аливаа өвчин авах, халдварлах
- △ Гар, хөлөө гишгүүлэх

Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Эх малыг саахдаа чөдөр, тушаа хэрэглэх эсвэл төлийг нь ойр байлгах
-  Эх малтай аядуу зөөлөн харьцах
-  Малыг барих, харгалзах хүнтэй хамтарч ажиллах
-  Гарын арьс шалбарч, урагдаж гэмтсэн үед тухайн хэсгээрээ малын сүү, түүхий эд, бусад шингэн, ялгадсанд хүрч болохгүй
-  Мал амьтантай харьцахад тохирсон ажлын хувцас, гутал, НБХХ хэрэглэх (хүнсний бээлий гэх мэт)

ХОНЬ ХЯРГАХ



Болзошгүй осол, гэмтэл

- ⚠ Хайчаар гараа зүсэх, эсгэх
- ⚠ Хүлээс мултарч хонины хөл, эвэр, толгойд цохиулах
- ⚠ Хачигт хазуулах, биед шигдэх
- ⚠ Цахилгаан машин ашиглах тохиолдолд тогонд цохиулах






Урьдчилан сэргийлэх зөвлөмж

- 📖 Хонины хөлийг аль болох хөдөлгөөнгүй хүлэх
- 📖 Хайчны ам, үзүүрээс нөгөө гараа зайтай байлгаж хяргах
- 📖 Ажлын битүү хувцас, бээлий, малгай өмсөх
- 📖 Цахилгаан машин ашиглах тохиолдолд машины бүрэн бүтэн байдлыг шалгах, тосолгоо үйлчилгээг нь хийх, аюулгүй ажиллагааны заавар (ААЗ)-ын дагуу ажиллуулах






БОД МАЛ ТАМГАЛАХ



Болзошгүй осол, гэмтэл

-  Адуунд өшиглүүлэх
-  Хөлөө гишгүүлэх
-  Халуун тамганд түлэгдэх

Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Адуу малыг аль болох хөдөлгөөнгүй барьж байгаад тамгыг жигд дарах
-  Түрийгэй, зузаан гутал өмсөх (болж өгвөл хоншоор дээрээ төмөр хамгаалалттай гутал байх)
-  Халж улайссан тамгыг өөрийн болон бусад хүний биеээс хол зайтай барих
-  Тамга халаах зуухны ойр орчимд хүүхэд ойртуулахгүй байх
-  Халуун зуух болон тамгыг хөрсөний дараа өргөх, зөөх

ЭМНЭГ СУРГАХ






Болзошгүй осол, гэмтэл


△ Эмнэг адуу, тэмээнээс унах, ойчих



Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Дадлага туршлагатай, жин багатай залуусаар эмнэг сургах ажлыг хийлгүүлэх
-  Эмнэг сургах газрыг зөв сонгох
-  Ногт барих, суллах хүнтэй хамтарч ажиллах






МОРЬ УРАЛДУУЛАХ



Болзошгүй осол, гэмтэл

- △ Хурдан мориноос унах, ойчих
- △ Дөрөөнд чирэгдэх
- △ Нүд рүү гадны биет орох
- △ Нүүр ам руу чулуу, шороо үсрэх

Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Хууль тогтоомжид заасан насанд хүрээгүй хүүхдээр хурдан морь унуулахгүй байх
-  Морь унаач хүүхдийг хамгаалалтын хувцас, хэрэгслээр бүрэн хангах, тоноглох
-  Морь унаач хүүхэд нь дадлага, туршлагатай байх
-  Хамгаалалтын хувцас, хэрэгсэл нь хүүхдэд таарсан байх, биед нь эвтэйхэн, аливаа хөдөлгөөнд аль болох саад учруулахааргүй байх (MNS 6264:2018 стандарт мөрдөх)
-  Дөрөөнд хөл шурган орохоос хамгаалсан хоригтой байх эсвэл гутал, дөрөө хоёр нь таарсан байх




Мөн үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага буюу MNS 6264:2018 стандартад заасан шаардлагуудыг дагаж мөрдөх хэрэгтэй. Тус стандартад дараах байдлаар холбогдох шаардлагуудыг нь тогтоосон байдаг. Үүнд:

Морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, хэрэгсэлд тавигдах шаардлага (MNS 6264:2018)	
<p>Хамгаалалтын малгай</p> 	<ul style="list-style-type: none"> ✓ Малгай нь морин уралдааны спортын зориулалттай, учирч болох гэмтлээс сэргийлэх, үйлдвэрлэгчээс гаргасан холбогдох бичиг баримттай байх ✓ Малгайг зориулалтыг нь өөрчлөн, нэмэлт тоноглол хийж ашиглахыг хориглоно ✓ Малгай нь уралдаанч хүүхдийн толгойн бүслүүрийн тойргийн хэмжээнд тохирсон, бүч нь малгайны доод хэсгээс чихний урд, хойд талаар орж, эрүүн дор бэхлэгддэг байна. ✓ Малгайг өмссөн үед хэвтээ тэнхлэгийн дагуу 210 градус, дээшээ 7 градус, доошоо 30 градусаас багагүй өнцгөөр харах боломжтой байна.
<p>Юүдэн</p> 	<ul style="list-style-type: none"> ✓ Салхи жавар нэвтрүүлэхгүй, элдэв бүч, товчгүй зориулалтын уян сунамтгай материалаар хийгдсэн байна.
<p>Нүдний шил</p> 	<ul style="list-style-type: none"> ✓ Нүд, нүүрэнд гэмтэл учруулахгүй, уян хатан материалаар хийсэн байх ✓ Орчны талбайг бүхэлд нь харах боломжтой, шилний хүрээ нь нүүрнээс хөндийрөхгүй, дээд, доод тал нь нүдний аяга, хажуу тал нь чамархайг далдалсан байна ✓ Агаар оруулахгүй жижиг нүхтэй, цантахгүй байх ✓ Хүүхдийн толгойн хэмжээнд тохируулах боломжтой байх

<p data-bbox="179 156 285 183">Хантааз</p> 	<ul style="list-style-type: none"> ✓ Хантааз нь морин спортын уралдааны зориулалттай, үйлдвэрлэгчээс гаргасан холбогдох бичиг баримттай байх ✓ Хантааз нь уралдаанч хүүхдийн хүйс, биеийн хэв шинж галбир хэмжээнд нийцсэн байна ✓ Хантаазны бүрэлдэхүүн хэсэгт мөрний хамгаалалт нэмэлтээр орж бэхлэгдсэн байна ✓ Хантаазны энгэр нь цээжний хэнхэрцэг яснаас доош 50 мм-ээс ихгүй байх ✓ Хантааз нь цээжийг бүхэлд нь тойрч бүрхсэн байх ✓ Хантаазны урд энгэр эгэмний товгор яс, хойд тал нь хүзүүний доод үе, мөрний хамгаалалт нь мөрийг бүрэн далдалсан байна ✓ Хантааз нь нуруу хэсгийг бүхэлд нь бүрхэн далдалж доргилтоос хамгаалсан байх ба хойд хормой нь эмээлийн бүүрэгт хүрэхгүй байх ✓ Сэрүүн, бороотой үед хантаазны гадуур цув, хүрэм зэргийг өмсөж болно
<p data-bbox="190 821 280 849">Бээлий</p> 	<ul style="list-style-type: none"> ✓ Гарын арьс салст эсгэж, зүсэгдэх, няцрах, зулгарах болон осгох зэрэг гадны үйлчлэлээс хамгаалах зориулалттай байна ✓ Бээлий нь бат бэх байж, гарын хөдөлгөөнд саад учруулахааргүй байна ✓ Бээлийний алган тал эрхий хуруу бүрхсэн халтирахаас хамгаалсан нэмэлт давхарлагаатай байж болно
<p data-bbox="128 1101 341 1128">Өвдгөвч, тохойвч</p> 	<ul style="list-style-type: none"> ✓ Хатуу биет дээр унахад цохилтын хүчийг сааруулж, хамгаалах чадвартай хөнгөн, чанартай материалаар хийгдсэн спортын зориулалттай байх ✓ Өвдөг, тохойны үнд таарах хэсэг нь тусгайлсан хатуулгатай, дотор болон бусад хэсэг нь зөөлөвчтэй байна. ✓ Хөдөлгөөнд саад учруулахгүй, мултрахгүй, үений хоёр талд өргөн резин, зангуун туузаар бэхлэгддэг байна.

Шилбэ, шууны хамгаалалт	<ul style="list-style-type: none"> ✓ Гарын бугалга шуу, хөлийн шилбэ хамгаалсан тусгай хамгаалалт нь биеийн тухайн хэсгийг болзошгүй эрсдлээс хамгаалахад зориулсан байна ✓ Хамгаалалтын хэрэгсэл нь өргөн резин, зангуун туузаар бэхлэгддэг байна. Уяа бүч хэрэглэхийг хориглоно.
	<ul style="list-style-type: none"> ✓ Шилбэ бүрхсэн түрийтэй гуталнаас өөр төрлийн богино түрийтэй, пүүз, үдээстэй гэх мэт төрлийн гутал өмсүүлэхийг хориглоно. ✓ Хүүхдийн хөлийн хэмжээнд тохирсон байна. Холхиж сугардаг болон бариу байж болохгүй. ✓ Гутлын бүтэц нь шагай болон шилбийг хамгаалсан нэмэлт хатуулга, хамгаалалттай байж болно. Энэ нь хөдөлгөөнд саад учруулахааргүй байна. ✓ Гутлын өсгийний зузаан 20 мм-ээс ихгүй байна. Өсгийгүй гутал өмсөхийг хориглоно. ✓ Гутлын ул, өсгий нь зөөлөн резин болон каучик материалаар хийгдсэн байх бөгөөд гулсах материал болох арьс, шир гэх мэт байж болохгүй. ✓ Гутланд нэмэлт тоноглол хийхийг хориглоно.
Гутал	
	

Хурдан морины хэрэгсэлд тавигдах шаардлага (MNS 6264:2018)	
Эмээл	<ul style="list-style-type: none"> ✓ Эмээл нь өндөр бүүрэггүй байна. ✓ Эмээлийн бүүрэг нь уралдааны үед хүүхдийн биеийг холгохгүй, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй материалаар хийгдсэн, эргономик байна. ✓ Эмээлийн суудал, гөлөм, олом, даруулга олом, жирэм, угсуурга, дөрөө холбооны тоноглол иж бүрдлийг шаардлагад нийцсэн сунаж агшдаггүй чанартай материалаар хийсэн байна. ✓ Тохмыг эсгий, зулхай зэрэг чичиргээ, доргилтын хүчийг сулруулах, хүчний үйлчлэлд тэсвэртэй, эдэлгээ даах чанартай материалаар хийсэн байна.
	

<p>Дөрөө</p> 	<ul style="list-style-type: none"> ✓ Дөрөө нь уралдаанч хүүхдийн биеийн жин, хүчний үйлчлэлийг тэсвэрлэх бат бөх байна. ✓ Хэт хүчтэй цохилтын үйлчлэлд эвдрэх тохиолдолд үзүүр ёзоор үлдээхгүй материалаар хийгдсэн байна. ✓ Дөрөөний таваг нь гутлын улыг үл хальтруулах иржгэр гадаргуутай эсвэл нүхтэй байна. ✓ Дөрөөний хэмжээг уралдаанч хүүхдийн өмсөх гуталд тааруулан хоршуулна. ✓ Уралдаанч хүүхдийн өмссөн гутлын харьцаанд хоршиж тохироогүй хэт томдож эсвэл багадсан дөрөө хэрэглэхгүй. ✓ Дөрөөнд хөл шурган орохоос хамгаалсан хоригтой байж болно. ✓ Морины дөрөө, жолооны сур нь залгаастай байж болохгүй.
<p>Хазаар</p> 	<ul style="list-style-type: none"> ✓ Хазаар нь эдэлгээ даах сур болон хүүхдийн гарыг холгож, эсгэхгүй, бат бөх материалаар хийсэн байна. ✓ Хазаарын сагалдарга бат бөх уягдсан байна. ✓ Уралдааны морины наснаас хамааран жолооны урт нь дараах хязгаарт байна. Үүнд: НЭГ. Азарга, их нас, соёолон (2,0-2,5) м; ХОЁР. Хязаалан, шүдлэн (1,5-2,0) м; ГУРАВ. Даага 1,5 м-ээс ихгүй байна. ✓ Амгай, зуузайг зэвэрдэггүй гангаар гагнаж хийсэн, морины аманд тохирсон байна.
<p>Ташуур</p> 	<ul style="list-style-type: none"> ✓ Ташуурын мод нь (2,0-2,5) см-ийн голчтой, (20-25) см урт байна. ✓ Ташуурын сурын урт нь 35 см-ээс ихгүй байна. ✓ Ташуурын сагалдаргын нийт урт нь 30 см-ээс илүүгүй байх ба сураар хийсэн байна.

Малчид та бүхэн хурдан морио уралдуулахдаа дээрх стандартын шаардлагуудыг дагаж мөрдөхөөс гадна Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолд заасан зохицуулалтыг санах хэрэгтэй. Тус тогтоолд жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосон байдаг.





МАЛ ХӨНГӨЛӨХ



Болзошгүй осол, гэмтэл

- △ Хүлээс сулрах, мултрах
- △ Малд хазуулах, өшиглүүлэх
- △ Мал засах хутганд гараа зүсэх, гэмтээх




Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Бод малыг найдвартай уяа, сураар хүлэх ба олуулаа хөдөлгөөнгүй болгож дарах
-  Бог малын хойд, урд 2 хөлийг нь тус бүр зөрүүлж бариад гадагш нь тэлэх маягтай хөдөлгөөнгүй дарах
-  Мал засах хутгыг иртэй байлгах бөгөөд гараа зүсэхээс болгоомжлон ирийг гар, биеэс гадагш чиглэлтэй барьж ажиллах
-  Гартаа ил шархтай хүн мал засахгүй байх







ТЭМЭЭ УНАХ, СААХ, ТУУХ



Болзошгүй осол, гэмтэл

-  Тэмээнээс унах, ойчих
-  Тэмээнд тийрүүлэх, хазуулах, дэвсүүлэх
-  Тэмээтэйгээ бүдрэх, ойчих

Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Тэмээг ботго байхад нь сайн уях, номхоруулах
-  Тэмээг тушихдаа аядуу зөөлөн харьцах, аргадах
-  Тэмээнд хэт хүнд, овор ихтэй ачааг нэг тал руу нь хэлтийлгэн ачихгүй байх
-  Тэмээ үргэх, бүдрэх газраар аль болох явахгүй байх
-  Ингэ саахдаа хойд 2 хөлийг нь туших эсвэл ботгыг нь ойр байлгах
-  Тэмээний хойд 2 хөлийн ойр, араар нь явахгүй байх






МАЛ ТӨХӨӨРӨХ, ХҮНС ХИЙХ



Болзошгүй осол, гэмтэл

- △ Хутгаар гар, биеэ зүсэх
- △ Малын ясанд гараа нидрэх, урах, шалбарах
- △ Малын хөлд тийрүүлэх



Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Хутгыг сайтар ирлэх, нөөц хутгатай байх
-  Гарт эвтэй бээлий өмсөх
-  Мал түшлэж байгаа хүний гар, биеэс аль болох зайтай ажиллах
-  Мах эвдэхдээ хутганы ирийг гар болон биеийн эсрэг тал руу харуулах чиглэлтэй ажиллах
-  Бог мал түшлэж байгаа хүн хөлийг нь хөдөлгөөнгүй барих, бод малын хөлийг сайтар хүлэх






БОД МАЛААР ОТОР, НҮҮДЭЛ ХИЙХ



Болзошгүй осол, гэмтэл

-  Тэнжээ, татлага сулрах, ачаа унах, ачаанд дарагдах, хавчуулагдах
-  Мал үргэж хүн, ачааг унагах


Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Тэнжээ, татлагыг сайтар бэхэлж, үе үе шалгах
-  Ачаа ачаад явж буй малын ойр орчимд том хүн болон хүүхэд явуулахгүй байх, хол зайтай явах
-  Ачааг хүндийн жингээр нь жигд хуваарилах, тэнцүүлэх
-  Боломжтой бол мал үргэхээргүй, хог болон элдэв зүйлс багатай, үнэг, хярс гэх мэт хээрийн амьтад багатай газраар явах, нүүдэллэх
-  Нүүх явцад малаа амрааж ачааг түр буулгах





ЭВЭРТЭЙ МАЛТАЙ ХАРЬЦАЖ АЖИЛЛАХ



Болзошгүй осол, гэмтэл

-  Хонь, ямаа, үхэрт мөргүүлэх
-  Эвэрт нь гар хөл, биеэ урах, сэжлүүлэх, хатгуулах

Урьдчилан сэргийлэх зөвлөмж

-  Эвэртэй малтай болгоомжтой харьцах ба эврээс нь нүүр, нүдээ хол байлгах, зай барих
-  Өвс тэжээл тарааж өгөх болон услахдаа аль болох доош сууж, бөхийж тонгойхгүй байх
-  Эвэртэй малыг тэврэх, өргөх, зөөхдөө эврээс нь барих, эсвэл нүүр, толгойгоо зайтай байлгах
-  Хангал, догшин эвэртэй малаас хол байх, зай барих

Аливаа малтай зөв харьцах, аядуу зөөлөн харьцах нь малчин хүнд байх чухал чадваруудын нэг юм. Ялангуяа адуу бол хатуу ширүүн үйлдэлд дургүй, аядуу зөөлөн үйлдэлд дасдаг, их ухаантай амьтан юм. Орчин үеийн малчид морь гэхээсээ илүүтэй мотоцикл, машин унах нь элбэг болж байна. Энэ нь бидэнд зарим талаар боломжуудыг олгодог ч, нөгөө талаас нь харвал тохиолдож болзошгүй осол, гэмтлийн нөхцөл байдлыг өөрчилж байдаг. Тодруулбал мориноос унах, машинтай осолд орох хоёрын ялгаа юм. Иймд морь унах нь эрүүл мэндэд сайн, 30 гаруй булчин зэрэг ажиллаж байдаг хэмээн өвгөдүүд хуучлан суудгийг залуу малчид сонортоо авна бизээ.




Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжүүдийг өдөр тутмынхаа үйл ажиллагаанд мөрдлөг болгон хэрэгжүүлж, дадал зуршил болговоос, эрүүл мэнд, амь нас, эдийн засгийн хохиролгүй ажиллаж амьдрах боломжтой гэж үздэг. Гэвч аливаа зүйлсийг бүгдийг нь урьдчилан таамаглаад байх боломжгүй байдаг тул гарцаагүй тохиолдсон осол, гэмтлийн үед орлогын баталгаагаа хангах, хүндрэл багатай даван туулах арга замыг эрэлхийлэх хэрэгцээ, шаардлага үүсдэг. Үүнийг зохицуулах нэг арга зам бол нийгмийн даатгалд хамрагдах явдал юм.

Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, газар тариалан эрхлэгч иргэд даатгуулж болох бөгөөд харъяа аймаг, дүүрэг, сумын Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-тай гэрээ байгуулан тодорхой нөхцөлүүдийг харилцан тохиролцож тус тусынхаа үүргийг биелүүлдэг. Ингэснээр дараах 3 төрлийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрхтэй болдог байна.











I	Тэтгэврийн даатгалын сангаас:	1	Өндөр насны тэтгэвэр
		2	Тахир дутуугийн тэтгэвэр
		3	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
II	Тэтгэмжийн даатгалын сангаас:	1	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
		2	Жирэмсний болон амаржсаны тэтгэмж
		3	Оршуулгын тэтгэмж
III	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас	1	Тахир дутуугийн тэтгэвэр
		2	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
		3	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж
		4	Хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр
		5	Тэтгэврийн даатгалын шимтгэл
		6	Рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувилалд ирэх, очих унааны зардал
		7	Мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувиллын тусламж, үйлчилгээний зардал

Сайн дураар даатгуулагч нь үйлдвэрлэлийн осолд орсон тохиолдолд, осолд өртсөн тухайгаа оршин суугаа аймаг, сум, дүүргийнхээ нийгмийн даатгалын хэлтэс (ажилтан)-д мэдэгдэх бөгөөд ослын актыг аймаг сум, дүүргийн засаг даргын томилсон комисс судлан тогтоодог болно.

ГУРАВ. ОРЧНЫ ЭРС ТЭС ТЕМПЕРАТУРЫН СӨРӨГ НӨЛӨӨ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ












 Цасан ба шороон шуурганы аюулаас урьдчилан сэргийлж авах арга хэмжээ



-  Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ, сэрэмжлүүлгийг радио, телевиз, гар утас, интернетээр тогтмол хүлээн авч гэр бүл, мал аж ахуй, хашаа хороогоо хамгаалах бэлэн байдлаа хангах.
-  Аюулт үзэгдлийн үед өөрийн ба бусдын эрүүл мэнд, амь насыг хамгаалах, аврах, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх мэдлэг, чадвар эзэмшсэн байх.
-  Хоол хүнс, ундны ус, түлш, эм, дулаан хувцас, ариун цэврийн хэрэглэлийг бэлтгэх.
-  Гар утас, радио, телевиз, гэрэлтүүлэх хэрэгслийг цэнэглэж бэлэн байлгах.
-  Бичиг баримт, үнэт зүйлсээ найдвартай газарт хадгалах, түүнийг гэр бүлийн гишүүд мэддэг байх.
-  Гэрээ салхинд унахаас хамгаалж хүнд зүйлээр даруулах.
-  Цахилгаан дамжуулах агаарын шугамын ойр гэрээ барихгүй байх.
-  Хүүхэд, жирэмсэн эх, өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хараа хяналтандаа байлгаж, аюулгүй байдлыг нь хангах.
-  Өвс тэжээлийн нөөц бэлтгэж, хашаа хороогоо бэхэлж, дулаалан, худаг усыг хамгаалах.
-  Нөмөр нөөлөг газруудыг тогтоож аван түүнийг хүн бүр мэддэг байх.


Шуурганы үед авах арга хэмжээ



-  Сэрэмжлүүлэх мэдээг байнга хүлээн авч заавар, зөвлөмжийг биелүүлэх.
-  Ойр дотныхондоо мэдээлэх.
-  Аян замд гарахаас зайлсхийх.
-  Замд гарах зайлшгүй тохиолдолд техникийн бүрэн, бүтэн байдал, найдвартай ажиллагаа, шатахууны нөөц, явах зам, хоол хүнсний нөөц, дулаан хувцас, гал асаах хэрэгсэл (шүдэнз, цаас), түлш (мод, аргал, хомоол, хөрзөн), жолоочийн туршлага, ур чадварыг харгалзах.
-  Гал түймрийн аюулаас болгоомжлох, шаардлагатай тохиолдолд цахилгааныг салгах.
-  Гадагш гарах зайлшгүй үед биедээ элбэг таардаг, хөлөргөдөггүй, хөнгөн, дулаан хувцсыг өмсөх.
-  Гадуур хувцас нягт нэхээстэй, ус нэвтэрдэггүй, юүдэнтэй байх.
-  Хүн биеийн дулаанаа толгойгоороо их алддаг тул заавал малгай өмсөх.
-  Төөрсөн үед тухайн газраасаа холдолгүй нөмөр газар бараадаж тэнгэр онгойхыг хүлээх.
-  Осгохгүйн тулд унтаж үүрэглэлгүй байнга хөдөлгөөнтэй байх.
-  Өрх гэрт гарсан хохирол, бодит нөхцөл байдлыг эрүүл мэнд, онцгой байдлын байгууллага, нутгийн захиргаа, иргэдэд заавал мэдээлэх.


Шуурганы дараа авах арга хэмжээ

- ☞ Цаг агаарын шинэчилсэн мэдээллийг тогтмол сонсох.
- ☞ Гэр бүл, ойр дотны хүмүүс, ялангуяа хүүхдийн сэтгэл санааг тайван байлгах арга хэмжээг авч тэдэнд туслах.
- ☞ Аюул, ослын дараах эрэн хайх, аврах, сэргээн босгох үйл ажиллагаанд хүүхэд оролцуулахгүй байх.



Гэр, орон байрнаасаа зайлшгүй гарах тохиолдолд мөрдөх дүрэм

- ☞ Хүүхэд, жирэмсэн эх, өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээ асран хамгаалагчтай үлдээх.
- ☞ Төөрч, осгохоос болгоомжлох.
- ☞ Цас, шороо, хүйтэн агаараас хамгаалж малгай, ороолт, бээлий, нүдний шил, цув өмсөх.
- ☞ Хүний эрүүл мэнд, амь настай холбоотой мэдээллийг гар утсаар шуурхай, цаг алдалгүй холбогдох газарт мэдэгдэх.



Хэт халалт

Халуунд гадаа удаан байх үед маш их хөлөрч, шингэн дутагдсанаас ядарч, толгой эргэж өвдөн, дотор муухайрч, шөрмөс татаж, зүрхний цохилт суларч удаан болно. Энэ нь хүн биеийн дулаанаа алдаж байгаагийн шинж тэмдэг мөн. Энэ үед сэрүүн газар бараадан, шингэн зүйл уух хэрэгтэй. Шингэн зүйл ууснаас нэг цагийн дараа дээрх шинж тэмдгүүд илэрсээр байвал, эсвэл бүр хүндрэн бөөлжиж эхэлбэл яаралтай эмнэлгийн тусламж авах хэрэгтэй. Биеийн температур цельсийн: 38 градусаас ихгүй байвал халуурахын өмнөх, 38.1-39 градус байвал дунд зэргийн, 39-41 градус байвал өндөр, 41 градусаас дээш байвал хэт өндөр халуурч байна гэдэг.

Халуунд цохиулах (нарших) гэдэг нь биеийн дулаан 40°C –ээс нэмэгдэж төв мэдрэлийн тогтолцооны үйл ажиллагаа алдагдсаны улмаас дэмийрэл, ухаан алдалт, эсвэл кома үүсдэг онцлогтой хүнд зэргийн эмгэг болно. Тиймээс тухайн хүний халууныг хурдан буулгах арга хэмжээ авах хэрэгтэй.



ШИНЖ ТЭМДЭГ



1. Арьс хэт халах, хуурайших

2. Их хэмжээгээр хөлрөх

3. Ухаангүй болж ком-д орох

4. Толгой эргэх, ухаан алдах

5. Булчин сулрах, ядрах, сульдах

6. Зүрхний хэм хурдсах, амьсгал давчдах

7. Зан авир, үйл хөдлөл тогтворгүй болох

8. Биеийн халуун 40°C-ээс дээш болох



АНХНЫ ТУСЛАМЖ



1 Нэрвэгдэгчийг сүүдэр газар хэвтүүлэх, дотогш оруулах

2 Түргэн тусламж дуудан, мэргэжлийн тусламж иртэл дараах арга хэмжээг авч байх хэрэгтэй

3 Хөлийг дээш өргөн барьж байх

4 Ухаан алдаагүй бол бүлээн ус уулгана

5 Хувцсыг тайлах




Бага багаар ус шүршиж сэрүүцүүлнэ

Чийгтэй даавуу,


7 мөсөөр суга, хүзүү, цавь, шагайн дээр жин тавина



8 Нэрвэгдэгчийг хүйтэн агаар, сэнс зэргээр сэрүүцүүлэн түргэн тусламжийг хүлээнэ



⚠ Хүйтний стресс



ХҮНИЙ БИЕЙН АМАРХАН ХӨЛДӨХ ХЭСГҮҮД:

чих хамар, хацар, хуруу

ХӨЛДӨЛТИЙН ШИНЖ ТЭМДЭГ:

Арьсны өнгө хэвийн үеийнхээс цайрах, хүйтэн, хуурай болох.

Хөлдсөн хэсгээр өвдөх, халуун оргих, хорсох, хавагнах.

Хөлдсөн хэсэгт 24 цагийн дараа цэврүү үүсэх.

АВАХ АРГА ХЭМЖЭЭ:

1. Халуун бүлээн шингэн зүйл уулгах
2. Нойтон хувцсаа тайлах
3. Хөлдсөн хэсгийг бүлээн усанд 30 минут байлгах
4. Нүүр, чихэнд бүлээн алчуураар жин тавих

ХИЙЖ БОЛОХГҮЙ ЗҮЙЛС:

1. Арьсыг үрж дулаацуулж болохгүй
2. Галд ээх, халуун жин тавих зэргээр арьсыг халааж дулаацуулж болохгүй.
3. Үүссэн цэврүүг хагалж болохгүй
4. Хөлдсөн мөчүүдийг хүчээр нугалж болохгүй





⚠ Хүйтэн бороо

Үргэлжилсэн хүйтэн борооноор малчид малаа уруудуулж үедүүлж осгоох, алдсан хойноо эрэл суралд орох, түлш, аргалаа норгох, даарч бээрэх эрсдэлтэй байдаг. Иймд найдвартай унаатай байх, борооны цув өмсөх, мал сүрэг, бэлчээр нутаг, түлш, усаа базааж бэлдсэнээр болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.




- △ Өдөртөө улам үүлшин, оройдоо тэнгэр бүрхэн салхигүй, гэнэт нам гүм болбол дуу цахилгаантай бороо орохын шинж гэж ярих нь ч бий.
- △ Шируун аадар бороо, мөндөр орвол богино хугацаанд их уснаас хүчтэй үер буух, их усанд хүн, мал осгох, гэр, байшин, хашаа, хороо, мал үерт нэрвэгдэх эрсдэлтэй.
- △ Аадар бороо өргөн газрыг хамарч байвал аюул багатай. Бага газрыг хамарвал эрсдэл ихтэй.

Үргэлжилсэн хүйтэн бороо ба аадар борооны үед мөрдөх дүрэм

-  Хүүхэд, өндөр настан, жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг тэнгэрийн муухайд морьтой, явган аль ч тохиолдолд малд явуулахгүй байх.
-  Дуу цахилгаантай борооны үед морь ба мотоцикл унаж салхи сөрж хурдан давхивал аянганд өртөх эрсдэлтэй.
-  Дуу цахилгаантай борооны үед аянганд цохиулахаас сэргийлж хошуурсан малын өмнө зогсож болохгүй.
-  Гэрийн янданг буулгаж, бүх цахилгаан хэрэгсэл, гар утас зэргийг тэжээлээс нь салгах, унтраах.

Аянга цахилгаантай бороо



- △ Урьдчилан сэргийлэх мэдээг цаг тухайд нь хүлээж авдаг байх хэрэгтэй. Өгч буй мэдээг зөв ойлгосон байх.
- △ Аянганы дуу бүдэгхэн сонсогдож байсан ч өөрийн тань байгаа газар аянга буух эрсдэлтэй гэдгийг санаарай.
- △ Аянга цахилгаантай бороо орохоор нөхцөлтэй байвал яндангаа буулгаж, өрхөө бүтээн, хаалгаа хаана.
- △ Телевизийн антенныг брезент эсвэл даавуугаар бүтээнэ.
- △ Гэртээ байхдаа гар утас ба бүх цахилгаан хэрэгслээ салгана.
- △ Хөдөө хээр морьтой, мотоциклтой явах аюултай.


Харин мотоциклоос бууж газарт суугаад хөлийнхөө өлмий дээр цагариглан тонгойж суу. Гараа өвдгөн дээрээ тавиад, толгойгоо өвдөгнийхөө завсар оруул. Биеийнхээ гадаргууг аль болох бага болгож, биеийнхээ газартай нийлсэн хэсгийг мөн хамгийн бага байлга. Аянганы хүчдэл ихэвчлэн толгой дээрээс биш, газраар дамжин хүний биед ордог.




- △ Аянга нижигнэх дуу гармагц мориноосоо бууж доош сууна.
- △ Ойтой газар явбал захын ганц модноос холдоно.
- △ Ойр орчимд 5 метрээс өндөр мод байвал аянга модон дээр бууна. Модонд хэт ойртох аюултай. Модны их бие ба мөчрөөс 4 метрээс хол байвал аюул багатай.
- △ Өндөр уулын оройд, тэгш тал газрын голд болон нүцгэн хадан дээр байрлахгүй байх.
- △ Цахилгааны шон дээр аянга их буудаг учир шонгоос хол байх.



- △ Цахилгааны шон тааралдвал 2 шонгийн дунд хэсэгт чихээ дарж явган суувал аюул багатай.
- △ Биедээ металл эд зүүсэн, зүүгээгүйгээс үл хамааран аянга бууна. Ямар нэгэн байдлаар саваа мод, эсвэл тийм хэлбэртэй биетийг толгой дээрээ барихгүй байх.



- △ Машин дотор харьцангуй аюулгүй. Машин дээр аянга буусан ч дотор нь дамжиж орохгүй. Машиныхаа цонхыг заавал хааж, дээвэр ба цонхноос зайдуу суух хэрэгтэй. Даавуун хийгээд брезентэн бүрээстэй, бүхээгтэй машины тэвшин дээр аюултай.
- △ Нэг дор бөөнөөрөө байхгүй байх.
- △ Аль ч тохиолдолд ил задгай саванд шатамхай бодис хадгалахгүй байх.
- △ Нейлон, пролонон хувцастай байх нь цэнэг хуримтлагдах аюултай.
- △ Гэрийнхээ гадна тал, хашаа саравч, амбаар савнаас сул хог хаягдал, нуранги зүйлсийг зайлуул. Сул мөчир, түлээний мод нь хүчтэй салхинд таны гэр орныг сүйтгэх хэрэгсэл болж болзошгүй.



- △ Мал амьтдаа хамгаал. Малын хашаа саравчаа хамгаалж бэхэл. Хашаагаа барихдаа үер болсон үед мал өндөрлөг газарт гарч болохуйц байдлаар байрлуулаарай.
- △ Аянга буулгагчийг өөрийн гэр малын хороо, хашаа, бусад байгууламжийн дээр босгоорой. Аянга буулгагч нь аянганы цахилгаан хүчдэлийг газарт аюулгүйгээр буулгадаг тул аянганаас үүдэлтэй гал түймрийн эрсдэлийг эрс бууруулдаг.
- △ Борооны цув, шүхэр, гамшгийн үед хэрэглэх үүргэвч авч явбал цаг агаарын аюулт үзэгдлийг даван туулахад хялбар байх болно.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ, ЦАГ УУРЫН ЭРСДЭЛТЭЙ НӨХЦӨЛД АЖИЛЛАХ БЭЛЭН БАЙДАЛ

Монгол орны эрс тэс уур амьсгал мал аж ахуй эрхлэхэд ихээхэн хүндрэл учруулдаг боловч эртнээс нааш нүүдэллэн, эрдэнэт сүргээ өсгөн бойжуулж, нүүдлийн мал аж ахуй эрхэлсээр ирсэн эцэг өвгөд маань байгалийн бэрхшээлийг даван туулах мал маллагааны уламжлалт өв соёл, аргаа олон сургаал үгсээр дамжуулан өвлүүлсээр иржээ. Тухайлбал:



Бэлчээрийг зөв сонгох, мал маллагааны аргын тухайд:

- ☞ “Даваатай газар хонинд харш”;
- ☞ “Мал сүрэг өвсөөр цаддаггүй, шимээр цаддаг”;
- ☞ “Хэвтэр хуурай бол хивнэг дүүрэн”;



Цаг агаартай холбоотой:


- ☞ “Гунаан үхрийн эвэр хуга хөлдөм гурван ес”;
- ☞ “Дунд идэш, дулаан хэвтэш”.

Малчид хүйтэн бороо, салхи, шуурга хийгээд өвлийн цагт осгох, хөлдөх, зун аянгад цохиулах, шимэгчид хатгуулах, хазуулах, мал, амьтнаас өвчин авах, өдөр тутмын үйл ажиллагааныхаа явцад гэмтэх, бэртэх зэрэг эрсдэлтэй ажлыг гүйцэтгэдэг. Иймд байгалийн аливаа гамшгийг хохирол багатай даван туулахын тулд дараах ерөнхий санамжийг хэрэгжүүлэх нь чухал юм.



Гэрт бэлэн байх материаллаг эд зүйл:

- ☞ Ундны ус, мөс.
- ☞ Илчлэг хоол хүнс.
- ☞ Мэдээлэл холбооны хэрэгсэл (радио, гар утас, телевиз г.м).



👉 Эмийн сан, даралтны аппарат, ариун цэврийн ба ариутгалын хэрэгсэл.



👉 Гэрэлтүүлгийн ба гал ноцоох хэрэгсэл (гар чийдэн, лаа, шүдэнз, асаагуур).



☞ Дулаан хувцас, хөнжил.




☞ Түлээ түлш, гал ноцоох цаас, аргал, хомоол, хөрзөн, нүүрс г.м.



Түлшний мод




Аргал, хомоол



Хөрзөн



Овоолсон аргал



Нүүрс



Цаас




Хураасан аргал



Бэлтгэсэн түлшний мод

👉 Хүүхдийн тоглоом, ном.



👉 Гэр, орон байрны даруулга, татлага.

👉 Олс, сур, тод өнгийн давуу, утаат дохио, бэлэн мөнгө, чухал бичиг баримт, газрын зураг г.м.



Олс



Тод өнгийн давуу



Газрын зураг



👉 Хүрз, зээтүү, жоотуу, царил, араг, савар, хөрөө, сүх зэрэг багаж хэрэгсэл.




☞ Нэгээс доошгүй байнгын ажиллагаатай, цэнэгтэй гар утас.





☞ Морь, найдвартай ажилладаг бөгөөд бүрэн, бүтэн тээврийн хэрэгсэл.







Мөрдөх заавар

-  Хаврын тэнгэр хувирамтгай тул малаа нөмөр дулаан бараадуулж гэрийн ойр бэлчээх, тэжээх ба өөрөө дулаан хувцас өмсөх.



-  Хаврын улиралд нимгэн хувцаслах, хүйтэн хоол, унд хэрэглэх, буцалгаагүй хүйтэн ус ууснаар даарах, цусны даралт буурах, хоолой өвдөх, ядарч сульдах, арьс хуурайших, хатиг гарах эрсдэлтэй тул илчлэгтэй халуун хоол, цай идэж, ууж, дулаан хувцаслах.

Эрүүл мэндээ хамгаалах

-  Өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэндэд тогтмол анхаарал тавих.
-  Цаг агаарын эрс тэс өөрчлөлт, отор нүүдлийн үед осгох, хөлдөхөөс сэргийлж дулаан хувцаслах.
-  Ахмад настан, бие давхар, хөхүүл эх, бага насны хүүхдийг аль болохоор гэр болон төв суурин газарт байлгах, отор нүүдлээр явуулахгүй байх.
-  Эмнэлгийн яаралтай тусламж авах шаардлагатай тохиолдолд хамгийн ойрхон байгаа эмнэлэг, эмчид хүрч болох зам, утасны лавлах, байршлын мэдээлэлтэй байх.



- 📖 Илчлэгтэй, тэжээллэг хоол идэх, хүүхдийг хөхөөр дагнан хооллох, бага насны хүүхэд болон бие давхар, хөхүүл эхчүүдэд тэжээлийн бэлдмэлийг эмчийн заавраар хэрэглүүлэх.
- 📖 Цасан шуурга удаан үргэлжлэх үед гэрийн хаалга орчмын цасыг зайлуулж, цэвэрлэн зам гаргах.






- 📖 Хувийн ариун цэврийг сайтар сахих.
- 📖 Үхсэн малын сэг, зэмтэй болгоомжтой харьцан халдвараас хамгаалах дэглэмийг мөрдөхийн сацуу ариутгал, халдваргүйтгэл хийх.



Хөлдөх, осгох тохиолдол гарвал:






- 📖 Хөлдсөн хэсгийг цасаар арчиж, үрж, иллэг хийж үл болно. Гэмтээх аюултай;
- 📖 Дулаан гэр, байранд оруулах;
- 📖 Гарын хуруу, сарвуу хөлдсөн бол гарыг зөрүүлж суганы хонхорт бүлээцүүлэх;
- 📖 Биеийн хөлдсөн хэсгийг биеийн хөлдөөгүй хэсгийнхтэй ойролцоо температуртай усанд дүрэх. Халуун усанд дүрж үл болно;
- 📖 Халуун жин тавих, зуухны ойр дулаацуулах ба харин гэрлээр шарж үл болно.

Сэтгэл зүйн зөвлөгөө

-  Сэтгэл санааг тогтвортой байлгаж, бодит бэрхшээлийг айл саахалт, нутгийн захиргааны хийгээд тусламж, дэмжлэг үзүүлэхээр ирсэн хүмүүст тодорхой ярьж, зөвлөгөө авах.
-  Үүсч буй сэтгэлийн түгшүүр, айдас, мөн алга хөлрөх, толгой өвдөх, зүрх дэлсэх, амьсгаа давчдах, ходоод орчмоор өвдөх зэрэг зовиур илэрвэл бусдад заавал хэлэх. Энэ үед согтууруулах ундаа, тайвшруулах эм хэрэглэж үл болно.
-  Гэр бүлийн гишүүдийнхээ яриаг анхааралтай сонсох, бодит нөхцөл байдлыг ярилцах, хүүхдийн айдсыг сарниулж тайвшруулах, урмын үг хэлж зоригжуулан сэтгэлийн дэм өгөх, тоглоом наадгай тоглох.



Үйл ажиллагааны аюулгүй байдал



-  Ган, зуд хийгээд гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх, байгалийн бэрхшээлийг даван туулах арга ухааныг харилцан бие биеэсээ суралцах, ахмадын сургаалийг хэрэгжүүлэх.
-  Нутаг орон, бэлчээр, бууцаа зөв сонгох, орон нутгийн цаг агаарын байдлыг ажиглах, шинжих, цаг агаарын мэдээг тогтмол авч байх.
-  Цаг агаарын мэдээ, мэдээллийг тогтмол ашиглан цаг агаарын тааламжгүй үед мал сүргээ ойрын бэлчээрт хариулах.
-  Усны зохих нөөц, хашаа хороо бэлтгэх.
-  Бага насны хүүхэд, ахмад настан, бие давхар, хөхүүл эхчүүдийг малын хариулга маллагаанд явуулахгүй байх.

Ган





Хур бороо орохгүй удаж их халснаас агаарын ба хөрсний чийг багасан үр тарианы ургац алдах, малын бэлчээр хомсдон хүндрэл учрахыг ган гэдэг.

Халуун хуурай салхи үргэлжилж, өдөр халуун, шөнө хүйтэн сэрүүн амьсгалтай байх, газрын хөрс нягтарч хатах, жижиг булаг, шандын ус татарч ширгэх, хүн мал ундаасах нь түргэн, үүл гаравч бороо оролгүй ширүүн салхилж, өглөө, оройн нарны туяа улаан, тэнгэрийн хаяа тоос, манан татаж байвал зун, намрын улиралд урт удаан ган болохын шинж хэмээдэг.

Гангаас урьдчилан сэргийлж авах арга хэмжээ

-  Бороо орохыг хүлээн ойрын бэлчээрт малаа бэлчээж тарга үл авахуулдаг сургамж бий тул малаа зуншлагатай, өвс ногоотой нутаг оронд оторлох нь чухал.
-  Оторлохын өмнө туршлагатай малчныг отрын нутаг судлуулахаар илгээнэ.






-  Отор хийхдээ сувай чийрэг малаа түрүүнд нь явуулна.
-  Дараа нь богино хөлийн малыг авч нүүнэ.
-  Очих нутгийнхаа хөрсний чийгний хэр хэмжээг мэдэхийн сацуу хүн, малын халдварт өвчин байгаа эсэхийг судал.
-  Гантай газрын мал улдах нь түргэн байх тул нүүж явахдаа элс, хайрга, чулуугүй, зөөлөн хөрстэй газрыг дагуулан тууварлана.

Зуд

Өвлийн хэт их цас малын бэлчээрийг хумьж зуд болох гол хүчин зүйл болдог. Мөн хур тунадас багатай жил хар зуд болж мал хорогдох нь элбэг.

- ⚠ **Цагаан зуд.** Намар, өвөл, хаврын цагт их хэмжээний цас орж бэлчээр цасанд хучигдсанаас мал бэлчээрээс өвс олж идэх боломжгүй болно.
- ⚠ **Харын зуд.** Хүйтний улиралд удаан хугацаагаар цас оролгүй, нуур, гол, мөрөн, булгийн ус хөлдсөнөөс худгийн ус хүрэлцэхгүй болж, мал сүрэг усаар гачигдаж олноор хорогдох нөхцөл бүрдэхийг харын зуд гэнэ.
- ⚠ **Шуурган зуд.** Өвлийн улиралд шуурга удаан хугацаагаар үргэлжилснээс мал бэлчээрлэж чадалгүй тэжээлээр дутагдан, өлсөж, даарч олноор хорогдох нөхцөл бүрдэхийг шуурган зуд гэнэ.
- ⚠ **Хүйтний зуд.** Хүйтний улиралд үргэлжилсэн хоногоор их хүйтэрснээс мал бэлчээрлэж чадахгүй болж, улмаар тэжээл, хашаа дутагдсанаас бэлчээрийн мал өлсөж, даарч олноор хорогдох нөхцөл бүрдэхийг хүйтний зуд гэнэ.
- ⚠ **Хавсарсан зуд.** Шуурган, цагаан, хүйтний зуд, эсвэл харын, хүйтний, шуурган зуд хавсарч бэлчээрийн мал аж ахуйд бэрхшээл учруулж, ус, тэжээл хашаа дутагдсанаас малыг олноор хорогдох нөхцөл бүрдэхийг хавсарсан зуд гэнэ.
- ⚠ **Туурайн зуд.** Тухайн нутагт өвөлжилтийн байдал хүндэрч дээрээс нь гадны аймаг сумаас олон мал орж ирснээс бэлчээрийн даац хэтрэхийг туурайн зуд гэнэ.

Зудаас урьдчилан сэргийлж авах арга хэмжээ:

-  Байгаль, цаг уурын таатай жилүүдэд санхүүгийн нөөцөө бүрдүүлэх, тохиолдож болзошгүй ган, зудын гамшгийг давах бэлтгэлээ урьдчилан хангана.
-  Даатгалын байгууллагатай гэрээ хийж ган зуд, гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлж өөрийн амь нас, мал сүрэг, эд хөрөнгөө даатгуулах.
-  Үүл хөгжиж, өнгөрөх нь удаан, цас элбэг, бэлчээрийн өвс цасанд дарагдан мал бээрч даарах нь түргэн, уруудамхай болох аваас малаа тэжээх өвс хүрэлцэхгүй бол сувай чийрэг малаа түрүүвчлэн цас нимгэн, өвстэй газар оторлоно. Дараа нь богино хөлийн малаа авч нүүнэ.

- 📖 Хамтарч оторлох хэрэгтэй. Отрын малыг хариулах хүнд орон гэр, дулаан дах, хувцас, хоол хүнс, эм, анхны тусламжийн хэрэгсэл, найдвартай холбоо барих утас, шүдэнз, түлш, ажлын багаж хэрэгсэл (сүх, алх, хүрз, жоотуу г.м) зэргийг хангалттай нөөцтэйгээр бэлтгэж өгнө.
- 📖 Зузаан цас унасан, зудтай газраас нүүхдээ нэн түрүүнд адуу, үхрийг тууварлана. Дараа нь зам мөрөөр нь хонь, ямаагаа тууварлаж нүүнэ.
- 📖 Өргөн зуд болохоор бол онд үл орох тарга тэвээрэг муу малаа чийрэг мах чөмөгтэй байхад нь мах болгож, өвөл, хаврын улиралд элбэг хүрэлцэхээр бэлтгэж авна.
- 📖 Цас зудаас гарч нүүдэллэн ирэгчдийг нутаг бэлчээр, усаар гачигдуулахыг цээрлэнэ.
- 📖 Өвчин эмгэг бүхий малтай айл отор нүүдлийн айлын дунд хүн малын халдварт өвчин дэлгэрүүлэхийг цээрлэнэ.



! Үер





📖 Үерийн аюулаас урьдчилан сэргийлж авах арга хэмжээ:

📖 Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээ, дохиог хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн бусад эх сурвалжаас тогтмол хүлээн авч урьдчилан сэргийлж бусдад дамжуулна.






- 📖 Гэр, хашаа, саравч, орон байрыг үерийн усны зам, голын гольдрил, гуу, жалга, хуурай сайр, ус хальдаг эрэг, татамд барихгүй байх.
- 📖 Үерийн аюултай бүс нутгаас нүүх.
- 📖 Үер, усны аюулаас хамгаалах далан, суваг, шуудуу, хашлага барих.
- 📖 Үер, усны аюулын талаар хүүхдэд анхааруулга, сэрэмжлүүлэг өгөх.
- 📖 Хүүхдийг хараа хяналтгүйгээр гол мөрөн, нуур, цөөрмийн орчимд тоглуулахгүй, орхихгүй, малд явуулахгүй байх.
- 📖 Чухал бичиг баримт, үнэт зүйлсээ үерийн усанд урсах, норхоос хамгаалсан найдвартай газар хадгалах, түүнийг гэр бүлийн гишүүд мэддэг байх.
- 📖 Цэвэр ус, хүнсний нөөц, дулаан хувцсыг усанд автахааргүй орчинд хадгална.
- 📖 Гэнэтийн ослын болон эд хөрөнгийн даатгалд хамрагдах.
- 📖 Өндөр хүчдэл, цахилгааны дор гэр, сууцаа барихгүй байх.

Үер, усны аюулын үед авах арга хэмжээ

-  Гэрийн хаягааг шуух, гэрээ бэхлэх, хүүхэд, бие давхар, хөхүүл эх, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, өвчтэй хүмүүсийг аюулгүй газар байлгаж эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөө авран хамгаалах.
-  Байшингийн дээвэр, ургаа мод зэрэг аль ойрхон өндөрлөг газар гарах.
-  Үер бууж болзошгүй хавцал, хонхор, нам дор газраас холдож аль ойр байгаа өндөрлөгт гарч тэндээ хүлээх.
-  Цахилгаан хэрэгслийг хүчдэлээс бүрэн салгах.



-  Усархаг, үргэлжилсэн хүйтэн бороотой үед, мөн аадар бороо, мөндөр орж байхад мал хариулах, эрэлд явах, аян замд гарахыг хойшлуулах.
-  Өрх гэрт гарсан хохирол, бодит нөхцөл байдлын талаарх бусад мэдээллийг эрүүл мэнд, онцгой байдлын байгууллага, ажилтан, нутгийн захиргаа, мөн бусад иргэдэд заавал мэдээнэ.
-  Гол мөрөн үертэй үед усанд орох, гол гатлах, зугаалах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхгүй байх, загасчлах, мал услах, туухгүй байх.

Үер, усны аюулын дараа авах арга хэмжээ

- ☞ Бусдад туслах.
- ☞ Эвдэрч нурсан газраас холдож аюулгүй газар очих.
- ☞ Шаардлагатай бол эмнэлгийн байгууллагад хандах.
- ☞ Үерийн усаар халдварт өвчний нян тээгддэг тул цэвэрлэгээ хийх ба энэ ажилд мэргэжлийн байгууллагаас туслалцаа авах.









- ☞ Ундны усыг заавал буцалгаж хэрэглэх.
- ☞ Гараа тогтмол савандаж угаах.



- ☞ Үерийн усанд норсон хүнсний бүтээгдэхүүнийг устгах, хоол хүнс бэлтгэдэг ахуйн хэрэглээний сав суулгыг буцалгаж ариутгах.
- ☞ Булаг, худгийн усыг шавхаж цэвэрлэх.

Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх










Цас их орсон, өндөр уулсын орчим болон гуу, жалга, суваг, шуудуунд их хэмжээний цас хуримтлагдсан газруудад урин дулааны улирал ирж байгаатай холбогдуулан шар усны үер буух эрсдэлтэй.

-  Том жижиг гол, сайр, жалгын эрэг хөвөөнөөс зайдуу суурьшиж нүүдэллэх.
-  Гуу жалга, далан, шуудууг цэвэрлэж ус урсахад чөлөөтэй болгох, өөрөөр хэлбэл цас ихтэй уулын ам, бэл дагууд суурьшиж байгаа айл өрхүүд, аж ахуйн нэгж, байгууллага хашаа болон ойр орчмынхоо цасыг зайлуулах, суваг, шуудууг сэргээж, үерийн усны гольдрилыг өөрчлөх зэрэг шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.
-  Цасны усаар дамжин амьтны сэг зэм гол руу орж ус бохирдуулах, халдварт өвчин тараах аюултай тул орон нутгийн холбогдох байгууллагаас цэвэрлэгээ, ариутгал, устгал хийх.
-  Бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх, гол, мөрний мөсөн дээр тоглуулахгүй байх.
-  Жолооч нар газрын гадаргын цасан бүрхүүл, голын цас, мөс хайлах, шар усны үерийн улмаас эвдэрч нурсан зам, гүүр болон гол, нуурын мөс цөмрөх магадлалтай газруудаар зорчиж үл болно.
-  Зөвшөөрөгдсөн зам, гүүрээс өөр гарц гармаар зорчихгүй байх.



Объектын ба ой, хээрийн түймэр

Урьдчилан сэргийлэх

-  Тайван цагт өөрийн ахуйгаас хамаарч гал алдаж болзошгүй аюултай бүх зүйлсийг илрүүлж аюулгүй болго. Энэ нь гал түймрээс урьдчилан сэргийлэх үндсэн арга мөн.
-  Өсвөр, залуу шилмүүст ой, шатсан ой, хуурай, унанги мод ихтэй ой, мод бэлтгэлийн хаягдал, үлдэгдлийг цэвэрлээгүй талбай, өвслөг ургамлын нөөц ихтэй газар, модны доор ил задгай гал түлэхгүй байх.
-  Шатах, тослох материал шингээсэн цаас, даавуу, хөвөн болон бусад зүйлийг зориулалтын бус газар ил хаяхгүй байх.
-  Тээврийн хэрэгсэл, бусад техникийг шатахуунаар цэнэглэх үед тамхи татах, цонх, хаалгаар нь шатах, дэлбэрэх аюул бүхий хог, хаягдал, үнс, шүдэнз хаяхгүй байх.
-  Машин, техникийн утааны янданг оч баригчтай болгох.
-  Түлсэн гал, асаасан шүдэнз, татсан тамхины цог, нурмыг бүрэн унтраах.
-  Түймрийн хуурайшилт ихтэй үед ой, хээр ил задгай гал түлэхгүй байх.
-  Түймрийн аюултай үед гэр, байшин, майхан, малын хашаа, саравч, өвс тэжээл, худгийн эргэн тойронд 100 метрээс доошгүй өргөнтэй цурав татах, шороон зурвас гаргах.
-  Хүрз, сүх, гар хөрөө, хувин, тармуур зэрэг галын үед ашиглаж болохуйц багаж хэрэгслүүдтэй байх.

Гал унтраах анхан шатны хэрэгслүүд					
					
Хувин	Сэрээ	Галын хөнжил	Устай поошиг	Галын хор	Савтай элс, шороо
					
Дэгээ					

- 📖 Яндангийн цонолт, халалтаас хамгаалах. Пийшин зуухны яндангийн хамгаалалтыг галд тэсвэртэй материалаар хийж, яндангийн цонолт, халалтаас хамгаал. Яндангийн ил гарсан хэсгийн урт нь гэр, байшингийн дээврээс 60-80 см-ээс дээш байх шаардлагатай.
- 📖 Үнс, нурмаа ил задгай асгахгүй байх. Объектын түймрийн шалтгааны 36.5% нь ил, задгай асгасан цогтой үнс, нурмаас үүдэн гарч буй тул халуун үнс, нурмаа тагтай үнсний саванд хий.
- 📖 Гэмтэлтэй цахилгаан хэрэгслийг ашиглахгүй байх. Бүрэн ба бүтэн байдал нь алдагдсан, шалбарсан, зарим хэсгээрээ халалт үүсэж хайлсан, залгуур, унтраалга нь эвдэрсэн цахилгаан хэрэгслийг ашиглахгүй байх.
- 📖 Цахилгааны хэт их ачааллыг үүсгэхгүй байх. Нэг залгууртай салаалагч ашиглан олон цахилгаан хэрэгслийг залгаж, дамжуулагч утасны халалт ба цахилгааны хэт их ачааллыг үүсгэхгүй байх.
- 📖 Гэр орондоо бензин, солярка (дизелийн түлш), бусад шатах хийгээд тослох материалыг бүү хадгал. Хялбар гал гаргах асаагуур, шүдэнзийг хүүхдийн гар хүрэхээргүй газарт нууж тавь.
- 📖 Гэр орондоо утаа мэдрэгч суурилуулж, гал унтраагуур, гал унтраах хэрэгслийг байрлуул. Утаа мэдрэгчийн хувийн ажиллагаа ба гал унтраагуурын дотоод даралтыг тогтмол шалгаж гэр бүлийн гишүүддээ гал унтраах аргыг зааж сурга.
- 📖 Дуудлага өгөх, бусдад мэдэгдэх. Гал гарсан тохиолдолд 101 утсанд яаралтай дуудлага өг. Өөрөө дуудлага өгөх боломжгүй бол хөрш айлуудаасаа тусламж хүс, чанга дуугаар хашгирч бусдад мэдэгдэнэ.
- 📖 Унтраах арга хэмжээ авах. Галын машин ирэхийг хүлээлгүйгээр ус, элс, шороо, гал унтраагуур, норгосон зузаан хувцас, хөнжил, хучлага зэрэг гарын дор материал, хэрэгслээр гал унтраах боломжит бүх арга хэмжээг авна. Гал унтраахдаа өөрийгөө болон бусдыг эрсдэлд оруулах, эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх ба анхаарал, хяналтаа сулруулж үл болно.
- 📖 Галын машины орж ирэх замыг чөлөөлөх, мэдээллээр хангах. Галын машины орж ирэх замыг чөлөөлж гал гарсан газарт очиход нь тусалж газарчил. Гал сөнөөгч нарт галын голомт хаана байгааг тодорхой хэлж, гэр, байшингийн дотор хүн байгаа эсэхийг заавал мэдэгдэнэ.

Гал түймрийг унтраах аргууд

- ☞ Шороо цацах
- ☞ Зурвас татах
- ☞ Хөрсний өнгөн хэсгийг хуулах
- ☞ Анжисаар хориг хагалалт хийх
- ☞ Цуравдах
- ☞ Химийн аргаар унтраах
- ☞ Усаар унтраах,
- ☞ Гар багаж, үлээгч аппарат ашиглах зэрэг аргуудыг хэрэглэнэ.

Бага хэмжээний түймрийн үед зурвасыг 0.5 метр, их хүчтэй үед 1 метр ба түүнээс дээш өргөнтэйгөөр хийнэ. Түймрийн голомтыг эзэнгүй орхихгүй байх хэрэгтэй. Түймрийн замд орших ямар нэгэн гол, горхи, зөрөг зам зэрэг газрыг олох буюу эсвэл хориг зурвас татаж түймрийн эсрэг өвсийг шатаана. Түймэр ба цуравны гал нийлмэгц дөл асар өндөр болж үлэмж дуу гарган унтардаг.

Шүршдэг галын хорыг зөв ашиглах			
			
Лацыг авч түгжээг долоовор хуруугаараа тат	Галаас 2...3м зайд зогсож хошууг галын голомт руу чиглүүл	Гал унтраагуурыг босоо барьж бариулыг баз	Галын голомт руу “шүүрдэх” маягаар шүршинэ. Дөл багасах тусам ойрт

Бөмбөгөн (халалтаас өөрөө тээсрдэг) галын хорыг зөв ашиглах		
		
Галын голомтыг чиглүүлэн шидэх	Галын голомт руу өнхрүүлэх	Эрсдэлтэй газарт байрлуулах


ТАВ. МАЛ АМЬТНААС ХҮНД ХАЛДАХ ӨВЧНИЙ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ

⚠ Бруцеллэз

Бруцеллэз нь бруцеллын төрлийн нянгаар үүсч хүний цус шингэний тогтолцоо, тулгуур хөдөлгөөний эрхтэн, мэдрэлийн тогтолцоо, дотор эрхтнүүдийг давамгайлан гэмтээж, халуурах шинжээр илэрдэг өвчтэй мал, амьтнаас дамжин халддаг халдварт өвчин юм. Таагүй хүчин зүйлийн нөлөөллөөр уг өвчин хурцдах, олон дахин сэдрэлт өгч, архагших хандлагатай, улмаар хөдөлмөрийн чадварыг алдагдуулдаг.

⚠ Халдварлах байдал

Бруцеллэзоор адуу, үхэр, тэмээ, хонь, ямаа, гахайнаас гадна цаа буга, нохой, муур, туулай, үслэг ан амьтад мөн хулгана, зурам хүртэл өвчилнө. Манай орны хувьд хонь, ямаа, үхэрт бруцеллийн нянгийн халдвар илүү тохиолддог байна.



Бруцеллийн нянгууд буур, бух, хуц, ухна, бодон зэрэг өвчтэй эцэг мал, амьтны үрийн шингэн, эх мал амьтны төлийн ус, хаг, сүү, баас, шээс зэргээр ялгарч хүнс, ус, хөрс, орчныг бохирдуулдаг.



Бруцелла нь халуунд тэсвэр муутай боловч хүйтэн сэрүүнд удаан амьдарч чаддаг онцлогтой. Тухайлбал +550С-ийн хэмд 2 цаг, +600С-ийн хэмд 30 минут, +650С-ийн хэмд 15 минут, +700С-ийн хэмд 5 минутийн турш л тус тус амьд байх боловч буцалгахад эгшин зуур үхдэг байна. Харин тасалгааны дулаанд байгаа сүүнд 40, хөлдүү цөцгийнд 22, маханд 30-45, +100С-ийн хэмд байгаа ноос, ноолуур, хөөвөр, хялгас, арьс ширэнд 60-120, газрын хөрсөнд 150 хүртэл хоног, тогтоол усанд зун 3 сар, өвөл, хавар, намарт 5-6 сар, чийгтэй бууцанд 1.5-2 сар, үхрийн баасанд 4 сар, зулбадасанд 75 хүртэл хоног тус тус амьд байх ба бруцеллэзоос шалтгаалж хээл хаясан малын үгрээний шүүрэл, сүү, шээсээр 15 сарын хугацаанд ялгардаг байна.


Бруцеллийн нянгийн халдвар өвчтэй малыг нядлах, мах эвдэх, малын гэдэс дотор эрхтэнг цэвэрлэх, арьс шир боловсруулах, ноос ноолуур бэлтгэх, төл мал авах, мал саах үед гарын жижиг шалбархайгаар шууд хавьтлын замаар халдварлана.




Мөн бруцеллез өвчтэй мал амьтны түүхий болон дутуу боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн, түүхий сүү, баяслаг, цөцгий, амьтны цус зэргээр хоол боловсруулах эрхтэний замаар халдвар дамжина.

Бруцеллез өвчний эмнэл зүй

Бруцеллез өвчин нь мэдрэл, тулгуур хөдөлгөөний эрхтэн, зүрх судас, шээс, шээс дамжуулах эрхтнүүдийг зонхилон гэмтээдэг халдвар-харшлын өвчин. Бруцеллийн нянгийн халдвар нь цусаар биед тархан тодорхой эрхтнүүдэд (элэг дэлүү, ясны чөмөг) байрлан үрэвслийн голомтуудыг үүсгэдэг ба эсийн дотор шимэгчлэн амьдрах чадвар сайтай тул олон жилээр биед хадгалагдах боломжтой байдаг. Иймээс даарч хөрөх, ядарч сульдах, өвдөх, сэтгэл санааны хямралд орох зэргээр биеийн дархлаа сулрах зэрэг гадаад, дотоод сөрөг хүчин зүйлийн нөлөөнд үрэвслийн голомтууд идэвхжин задарч цусны урсгалд орж бусад эрхтнүүдэд үрэвслийн процессийг үүсгэж өвчин сэдэрдэг байна. Өвчнийг илэрсэн даруйд онош тодруулан бүрэн эмчилээгүйгээс архагших шалтгаан болно. Өвчний нууц хугацаа буюу өвчний шинж тэмдэг илрэх үе 7-30 хоног, анхны шинж тэмдэг илрээд хурц бруцеллезын үе 3 сар хүртэл, ужиг бруцеллез 3-6 сар, архаг бруцеллез 6 сараас илүү хугацаагаар үргэлжилдэг.

 **Бруцеллезын анхдагч хэлбэр:** Эмнэлзүйн шинж тэмдэг илрээгүй, өвдөөгүй боловч цусны шинжилгээгээр халдвар эерэг гарсан тохиолдол элбэг байдаг. Энэ үеийг шинж тэмдэггүй буюу анхдагч хэлбэр гэдэг. Голдуу урьдчилан сэргийлэх үзлэгээр оношлогддог. Гэвч шинж тэмдэг огт илрээгүй биш харин ажлын чадвар буурсан, хөлрөх, цочимтгой болох, захын тунгалгийн булчирхайнууд, элэг дэлүү бага зэрэг томорсон шинжүүд мэдэгддэг.


 **Бруцеллезын цочмог хэлбэр:** Энэ үед 3-5 хоногийн урьдал үетэй бие суларч ядрах, бие тавгүй болох, толгой өвдөх шинжүүдээр илэрч, өндөр халуурах, чичрүүлэх, хөлрөх, хордлогын шинжүүд нэмэгдэж, эмчийн үзлэгээр элэг дэлүү томрох, хүзүү, суганы булчирхайнууд өвчингүй томрох, гар хөлийн булчин, шөрмөсний дагуу арьсан доор өөхөн эслэг товруут зангилаанууд (фиброзит, целлюлит), зүрх зүүн тийш томрох шинжүүд гарна. Хордлогын байдал даамжрах үед хоолны дуршил буурч, хэвлийгээр өвдөх, сэтгэл санаа тогтворгүй, их ядрах, нойр хямрах, толгой өвдөх, үе мөч, булчингаар өвдөх, биеийн жин буурч, харшлын урвалууд илэрнэ. Лабораторийн шинжилгээнүүдэд өөрчлөлтүүд давамгайлан гарсан байдаг.

⚠ Архаг бруцеллэз

Ихэвчлэн цочмог болон ужиг хэлбэрүүд архагт шилждэг. Архаг бруцеллезын шинж тэмдэг нь дархлаа-харшлын урвал, иммуно-аллергийн шинжүүдэд суурилан илрэх ба эмнэл зүйн дараах хэлбэртэй байдаг. Үүнд:

- ⚠ Дотор эрхтний хэлбэр (Зүрх судасны, Уушгины, Элэг дэлүүний)
- ⚠ Үе хөдөлгөөний эрхтэн ба яс гэмтээсэн хэлбэр (Үеийг гэмтээсэн, Ясыг гэмтээсэн, Мөгөөрсийг гэмтээсэн, Хавсарсан)
- ⚠ Мэдрэлийн тогтолцоог гэмтээсэн хэлбэр (Төв мэдрэлийн тогтолцоог гэмтээсэн, Захын мэдрэлийн тогтолцоог гэмтээсэн, Мэдрэл сэтгэхүйг гэмтээсэн)
- ⚠ Шээс, бэлгийн эрхтнийг гэмтээсэн хэлбэр
- ⚠ Эмнэл зүйн хавсарсан хэлбэрүүд
- ⚠ Бусад (хумхаа, сүрьеэ, тэмбүү г.м) халдвартай хавсарсан гэж ангилна.


⚠ Тулгуур хөдөлгөөнийг гэмтээхэд үе, үений уут, яс мөгөөрсний хальс, шөрмөсний уут холбогч эдийн үрэвсэл хамгийн их тохиолдоно. Том үеүд улайж хавдах, хөдөлгөөн хязгаарлагдах, орчны эдийн үрэвслээс болж үе мөчөөр хүчтэй өвдөх, үе үе халуурах шинжүүд гарна. Үрэвслийн шинжүүд олон дахин сэдэрснээс үеийн жийргэвч мөгөөрс гэмтэж зузаарч, завсар зай нарийсан хоорондоо наалдаж бэхлэгдэнэ. Үүнийг үе мөчний өвчин артроз гэх буюу энэхүү өөрчлөлт нуруу нугалмуудад үүсэхийг остеохондроз, хөдөлгөөнгүй болохыг анкилоз гэнэ.



⚠ Төв мэдрэлийн системийн хямралын үед нойр хямрах, ядарч сульдах, цочимтгой болох, сэтгэх чадвар муудах, сэтгэл түгших, уурлаж цухалдах, сэтгэл тавгүйтлийн шинжүүд, хараа, сонсгол муудах, тэнцвэрийн мэдрэхүй алдагдал, гар хөлийн үзүүр хөрөх, арьсны тэжээлэг чанар алдагдаж, шөнө их хөлөрч, бие маш их сулрана.

⚠ Захын мэдрэлийн гэмтлийн үед мөр, хавирганы завсар, ууц нурууны суудлын мэдрэлийн ширхэг дагаж өвдөх, мэдрэхүйн өөрчлөлтүүд өгдөг.









⚠ Дотор эрхтний гэмтлийн үед хялгасан судасны нэвчимхий байдал ихсэх, зүрхээр өвдөх, хураагуур судасны тромбофлебит болох, уушгины хатгалгаа, биеийн жин буурах, элэг дэлүү томрох, хатуурах, үйл ажиллагааны алдагдлын шинжүүд гарна. Бөөр давсагны үйл ажиллагаа алдагдах, үр зулбах, дутуу төрөх, бэлгийн сулрал болох, үргүйдэлд хүргэх уршигтай.



Бруцеллёз өвчний үед төмсөг гэмтдэг, үргүйдэл, умайн үрэвсэл, үр зулбалт, үе үе халууралт, бие сулрах, хоолны дуршил буурах, үе мөч, тулгуур эрхтний гэмтлүүд үүснэ.

👉 Эмчилгээнд: Бактерийн эсрэг антибиотик эмчилгээ, үрэвслийн эсрэг эмчилгээ, хордлого тайлах эмчилгээ, харшил-халдварын эсрэг эмчилгээ, витамин эмчилгээ, дархалаа дэмжих эмчилгээ зэргийг хийдэг.

Бруцеллез өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?

-  Малтай айл өрх, байгууллагууд мал сүргээ жил бүр бруцеллез өвчнөөс сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамруулж вакцин хийлгэн бруцеллез өвчтэй малыг тусгаарлах
-  Төл хүлээх авах, арьс шир бэлтгэх, мал саах, ноослох, нядлах, өтөг бууц цэвэрлэхдээ ажлын хувцас, НБХХ /амны хаалт, хормогч, резинэн бээлий, нэг удаагийн комбинзон/ өмсөх, малын эхэс, зулбадсыг нүхэнд булах, устгахдаа дэгээ ашиглах, эдгээр үйлдлийн дараа гараа савандаж бүлээн усаар сайтар угаах
-  Түүхий сүү, цөцгий, махан бүтээгдэхүүн, элэг, цус, цусан бүтээгдэхүүнийг сайтар боловсруулж хэрэглэх
-  Түүхий мах хэрчсэн хутгыг угааж цэвэрлэлгүйгээр талх, хиам, бяслаг, алим зэрэг шууд хэрэглэдэг хүнсний бүтээгдэхүүнийг хэрчихгүй байх
-  Бууз, хуушуур, баншны махыг түүхийгээр нь амтлахгүй байх
-  Малын гаралтай түүхий хүнсний бүтээгдэхүүнтэй харьцсаны дараа гараа заавал угааж байх
-  Малын өтөг бууцыг дулааны улиралд овоолон хатаах, сийрэгжүүлэх ба 20%-ийн хлорын шохойн уусмалаар ариутгах
-  Халуурах, хөлрөх, толгой, үе мөч, ууц нуруугаар өвдөх, хоол унданд дургүй болох зэрэг шинж тэмдэг илэрвэл нэн дариу эмчид үзүүлж, шинжилгээ хийлгэн эмчлүүлэх хэрэгтэй.

Боом (Сибирская язва)

Боом нь өвчтэй мал амьтнаас хүнд халдварлаж хэсэг газрын шүүдэст, цусархаг, үхжилт үрэвсэл үүсгэн байршмал болон үжил хэлбэрээр явагддаг хурц халдварт өвчин. Манай орон мал аж ахуйн орон тул элбэг тохиолддог. Газар малтах зэргээс халдвар авдаг байсан тул “Газрын юм”, “Газрын яр” гэж нэрлэх нь ч бий. Боомыг үүсгэгч боомын савханцар *bacill Anthracis* нь гадуураа хуяган бүрхүүлтэй маш хүчтэй экзотоксин ялгаруулах чадвартай уургийн цогц юм. Хуяган бүрхүүлтэй учраас гадаад орчинд буюу өвчтэй малын ялгадас, шээсээр бохирлогдсон газрын хөрсөнд хэдэн арван жилээр хадгалагддаг. Боомын савханцар нь үхүүлэх, хавагнашуулах, бүрхүүлийн гэсэн гурван төрлийн хорыг ялгаруулдаг.


Халдварын эх үүсвэр нь өвчтэй үхэр, адуу, илжиг, хонь, ямаа, буга, тэмээ, ховор тохиолдолд тэжээвэр амьтдаас муур, нохой өвчилнө. Амьтдын боом өвчин дараах шинжээр илэрнэ.

- △ Маш богино хугацаа явагдах үе 3-4 хоногоос хэтрэхгүй (уушгины хэлбэр хувьд 2-3 долоо хоног байж болно)
- △ Хүнд хэлбэрийн халууралт, зүрх судасны үйл ажиллагааны алдагдал, менингит төст шинж, цусан суулга, бөөлжих шинжүүд өгнө.
- △ 2-3 хоногт үрэвслийн явц хурдацтай дамжирч үхэлд хүргэнэ.

Өвчтэй амьтны өтгөн шингэнээр нян гадагшлахад газрын хөрс боомын халдварыг хадгалагч эх уурхай болдог. Халдвар дамжих онцлогоос хамаарч эд эрхтний гэмтэл үүсэх байдал харилцан адилгүй байдаг.








△ Хүмүүс хэрхэн халдвар авах вэ? Халдварыг ямар замаар авснаас болж арьсны, уушгины, гэдэсний, үжил хэлбэрээр өвчилдөг. Өвчний явц тархалт, илрэх шинж нь хүний бие махбодийн болон түүний дархлааны урвалаас шалтгаална.

△ Арьсны хэлбэр – энэ хэлбэр нь хамгийн их тохиолддог ба голдуу ил газар нүүр, толгой, гар хөлийн арьсанд гардаг. Нянгийн орсон хэсэг хүрэн улаан толбо үүсч богино хугацаанд гүвдрүүтэн овойж, хэдхэн цагийн дотор цэврүүтэн өнгөгүй шингэн байснаа цусархаг болж, улмаар хүрэн ягаан шингэнээр дүүрнэ. Маш их загатнаснаас цэврүү хагарч, тав нь улам томорч харлана. Эргэн тойронд нь шинээр цэврүүнүүд үүсэх бөгөөд үүнийг боомын хатиг гэдэг. Богино хугацаанд цэврүүнүүд нийлэн хагарч, тавнууд нийлээд тас хар өнгөтэй болсныг Anthrax (нүүрс) гэж нэрлэдэг.



Биеийн эсэргүүцэл, гадна дотны хүчин зүйлээс болж арьсны хэлбэр нь үжилт хэлбэрт шилжиж болдог. Хүндэрсэн үед чичрэх, халуурах 39-41 хэм хүртэл халуурч, толгой хүчтэй өвдөх, зүрх дэлсэх, амьсгаадах, цээжээр өвдөж, цусан судалтай цэр гарч, хаггалгаа болно. Уушгинд цусан халдварын хаван үүсч хордлого-халдварын шоконд ордог. Энэ үед цэр, цусанд боом савханцар илэрнэ. Зарим өвчтөнд өмхий цусархаг суулгалт, цусаар бөөлжих, биеэр цусан тууралт, ихэвчлэн идээт тууралт үүсч яваандаа уушгины хавангийн улмаас нас бардаг.

Урьдчилан сэргийлэлт

-  Урьдчилан сэргийлэх арга хэмжээг мал эмнэлгийн албатай нягт холбоотой хийж гүйцэтгэх
-  Өвчтэй сэжиг бүхий амьтдыг тусгаарлах
-  Үхсэн малыг шатааж, 2 метрийн гүнтэй нүхэнд булах
-  Өвчтэй малын хэвтрийг ариутгах
-  Ноос, үслэг эдлэлийг камерын ариутгалд ариутгал хийлгэх
-  Өвчтэй амьтан, халдвартай материалтай холбоо барьсан хүмүүсийг 2 долоо хоногийн турш эмнэлгийн хяналтанд байлгах
-  Хувийн урьдчилан сэргийлэлтэнд зориулж боомын хүчийг нь сулруулсан амьд вакцин (СТИ)-ыг арьсан дээр зурж хэрэглэх.




Тарваган тахал (Чума)


Төв Азийн тарваган тахлын байгалийн голомтын зонхилох хэсэг нь манай орны нутаг дэвсгэрт оршдог бөгөөд экологи-газар зүйн онцлогийг харгалзан тахлын байгалийн голомтыг Уулт-хээрийн, Тал-хээрийн, Говь-хээрийн гэсэн хэв шинжид хуваадаг. Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 28.3% буюу 18 аймгийн 132 сумдын 443.3 км² талбай тарваган тахлын байгалийн голомттой бөгөөд байгалийн голомтонд мэрэгч, туулай хэлбэртэн амьтад тахлын агуулагчийн үүргийг гүйцэтгэдэг ба хээрийн бүсд араатан амьтад, махчин шувууд тодорхой хэмжээгээр оролцдог.

Тахлын үүсгэгч нь *Y.pestis* зууван хэлбэртэй Грам сөрөг савханцар. Тарваган тахлын нян бүүрэгний ходоодонд 0-150С хэмд 396 хоног хүртэл, мэрэгчдийн нүх ноохой, газрын хөрс, хүйтэн чийгтэй нөхцөлд олон сарын турш амьдрах чадвартай байдаг ба бичил биетний нөлөө, нарны гэрэл, химийн бодисын нөлөөнд тэсвэргүй.

Тархвар судлал нь Тарваган тахлаар өвчилсөн мэрэгч амьтан, шимэгчид (бүүрэг, бөөс...гм), өвчилсөн хүн халдварын эх уурхай болно. Гэрийн тэжээвэр амьтдаас нохой, муур мөн эх уурхай болдог. Тарваган тахлын нян байгальд МЭРЭГЧ-БҮҮРЭГ-МЭРЭГЧ гэсэн гинжин хэлхээнд оршиж байдаг зүй тогтолтой буюу дамжуулагч нь бүүрэг болдог.



⚠️ Халдвар дамжих хүрээ



⚠️ Тарваган тахал дараах замаар хүнд халдварлагдана.

- ⚠️ Шууд хавьтал – өвчтэй тарвага агнах, арьс өвчих, мах эвдэх, зэрэг үйл ажиллагааны явцад арьс салстын бүтэн байдал алдагдсан үед болон өвчтөнийг асрах, сувилах, халдвартай эд зүйлстэй хамгаалах өмсгөлгүйгээр харьцсанаас арьсны болон булчирхайн тахлаар өвчилнө.
- ⚠️ Дам халдварын зам – мэрэгч амьтдын бөөс, бүүрэг, цус сорогч үе хөлтөнд хазуулсан зэрэг тохиолдолд халдварлана.
- ⚠️ Агаар дуслын зам – тарваган тахлын уушгины хэлбэрээр өвчилсөн хүн, түүний нэгдүгээр хавьтлаас халдварлана.
- ⚠️ Хоол хүнсний зам – тахлаар өвчилсөн тарваганы мах, махан бүтээгдэхүүнийг дутуу боловсруулан хэрэглэх явцад халдварлана.

⚠️ Тарваган тахлаар өвчилсөн үед илрэх шинж тэмдэг:

- ⚠️ Халдвар авсан нууц үе дундажаар 3-6 хоног, харин тахлын вакцин хийлгэсэн тариулсан, антибиотик эмчилгээ хэрэглэсэн тохиолдолд нууц үе уртасч болно.
- ⚠️ Ерөнхий шинжүүд нь өвчин угтал үегүйгээр гэнэт эхлэх, бие дагжин чичирч богино хугацаанд биеийн халуун +39-+40 хэмд хүрч, толгой өвдөх, дотор эвгүйрэх, нүүр нүд улайх, бүх бие булчин өвдөх болон хордлогын шинжүүд илэрнэ.

⚠️ Тарваган тахал дараах эмнэл зүйн хэлбэрээр илэрдэг.

- ⚠️ **Тарваган тахлын арьсны хэлбэр** – нян орсон газар үрэвсэн улайж, толбо, гүвдрүү үүсгэн цусархаг шүүс бүхий цэврүү болж хувирдаг. Гэмтсэн хэсгийн өөхөн эд хавдаж, эмчилгээ эхлээгүй тохиолдолд үрэвсэл маш хурдан хугацаанд өвчин ихтэй хатиг болж хувирна.















- ⚠️ **Тарваган тахлын булчирхайн хэлбэр** – Гэмтсэн арьс салстаар нэвтрэн орсон тарваган тахлын нян үржин, шингэний урсгалаар ойролцоох тунгалагын зангилаанд хүрч цочмог үрэвслийг үүсгэж, ихэвчлэн суга, хүзүү, цавины булчирхай томорно. Тунгалагийн булчирхайнууд үрэвслийн улмаас орчны зөөлөн эдийг үрэвсүүлж, ойролцоох булчирхайнуудтай барьцалдан бэрсүү буюу моомыг (бубон) үүсгэнэ. Моом нь хатуурч томрон маш их өвдөлттэй болж өвчтөнийг албадмал байрлалд оруулна. Хэрэв булчирхайн хэлбэр нь хүндэрвэл уушгины хоёрдогч тахал, үжил, мэнэнгитээр хүндэрдэг байна.



- △ **Тарваган тахлын уушгины хэлбэр** – Тахлын нян агаар дуслын замаар амьсгалын дээд зам болон нүдний салстанд нэвтэрсэн тохиолдолд уушгины хэлбэрийг үүсгэх буюу аюултай хүнд хэлбэр юм. Өвчтөн өндөр халуурах, цээжээр хатгуулах, ханиалгах, цэр эхэн үед хөөсөрхөг, дараа нь цусархаг шингэн болж хувирна. Энэ үед цэрээр гадаад орчинд нян их хэмжээгээр тархдаг. Хоёр дахь өдрөөс уушгины хатгалгаа эхэлж, уушгины хялтан хальс үрэвссэнээс цээжний өвдөлт нэмэгдэж, амьсгалын дутагдлын шинжүүд давамгайлан өвчтөн агаарт гарах гэж тэмүүлж, сэрлийн байдалд ордог. Хүчилтөрөгчийн дутагдлаас төв мэдрэлийн тогтолцооны эмгэгүүд тод гарч, халдвар-хордлогын шоконд орох аюултай болдог.
- △ **Тарваган тахлын анхдагч үжил хэлбэр** – тахлын нян цусанд шууд орсноор шарх, моом, уушгины үрэвсэл зэрэг анхдагч голомтлог үрэвслийн шинжгүйгээр шууд эхэлдэг. Өвчтөн богино хугацаанд зүрх судасны дутагдалд орж халдвар-хордлогын шоконд ордог хүнд хэлбэр.
- △ **Тарваган тахлын гэдэсний хэлбэр** – ходоод гэдэсний талаас хүчтэй өвдөлт өгч, цусархаг зүйлээр бөөлжих, суулгалт илэрнэ. Энэ үед мөн өтгөнөөр тахлын нян ялгардаг.
- △ **Тарваган тахлын залгиур хоолойн хэлбэр** – энэ үед зовиур, шинж тэмдэг илрэхгүй байж болох учраас хөөмийн арчдасын шинжилгээ өгч илрүүлнэ. Ердийн хоолойн өвчинтэй төстэй боловч хүзүүний тунгалагийн булчирхайнууд томорч эмзэглэлтэй болсон байдаг. Тиймээс лабораторийн шинжилгээгээр оношлох хэрэгтэй.

Малчдын хувьд урьдчилан сэргийлэх арга зам

-  Тарвага агнахгүй байх
-  Тарваганы мах идэхгүй байх
-  Түүхий эд, эрхтэнг хэрэглэхгүй байх
-  Хүүхдийг тарваганы дошин дээр тоглуулахгүй байх
-  Шимэгчид хазуулахаас сэргийлэх, дайжуулагч хэрэглэх
-  Тарваган тахлын эсрэг вакцин хийлгэх
-  Гэр орондоо агнасан тарвага, арьс хадгалахгүй байх
-  Гэр орондоо мэрэгч амьтан орохоос сэргийлж хавх тавих, тор хийх, мэрэгчийн хор тавих, устгах
-  Нохойг байнга уяатай байлгах
-  Үхсэн, хөдөлгөөн удааширсан тарваганд хүрэхгүй байх
-  Тарваган тахлын эрсдэлд өртсөн, эмнэл зүйн шинж илэрсэн тохиолдолд харьяа эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх
-  Тарваганы түүхий мах, эд эрхтэнг хот суурин газарт оруулахгүй байх.

**ТАРВАГАН
ТАХЛААР ӨВЧИЛСӨН
ҮЕД ЭМНЭЛЭГИЙН
ТУСЛАМЖ ХЭРХЭН
АВАХ ВЭ?**

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ДУУДЛАГА ӨГӨХ



- Өвчтөн байгаа байрнаасаа гарахгүй байх.
Мэдээллийн хэрэгсэл ашиглан 103 эсвэл харьяа эрүүл мэндийн байгууллагад дуудлага өгөх.
Дуудлага өгөхдөө тарваган тахлын эрсдэлд өртсөн тухай мэдэгдэх.

ХАЛДВАР ДАМЖИХААС СЭРГИЙЛЭХ



- Аль болох хүмүүстэй уулзахгүй байх.
- Өөрийн байгаа газартаа хүн орж, гарах хөдөлгөөнийг хорих.

ТУСГААРЛАХ




- Тарваган тахлын эрсдэлд өртсөн байж болзошгүй өрхийн гишүүнийг эмч иртэл бусдаас тусгаарлах.
- Амны хаалт зүүлгэх.

⚠ Лептоспироз Васильевийн өвчин

Лептоспирозын байгалийн голомт нь шугуй, ширэнгэ ой, ойт-хээр, ойд нутагтай зэрлэг амьтад тухайлбал чийг зөөлөн хөрсөнд амьдардаг мэрэгчид, шавьж идэштнүүд, оготно, талын оготно, саарал харх, сохор номин, зараа, гэрийн амьтдаас үхэр, нохой, гахай, морь зэргийн дотор хадгалагддаг. Лептоспир нь нь эдгээр амьтдын бөөрний тахир сувганцарт хадгалагдаж байдаг учраас олон сараар шээсээр нь ялгарч байдгаас хөрс усыг бохирдуулж халдвар дамжих нөхцөлийг бүрдүүлдэг. Лептоспир нь зүсэгдсэн, шалбарсан арьс, салст, хамар, ам, нүдний салстаар хүний биед нэвтэрдэг. Мөн өвчтэй амьтад нуур цөөрөм, худгийн цэнгэг ус, хөрсийг бохирдуудаг учраас хүмүүс усанд сэлэх, түүхий ус уух, бохирлогдсон хүнс хоол хэрэглэсний улмаас халдвар авдаг. Иймд голдуу малчид, газар тариалан, намаг нугатай газар ажилладаг хүмүүс зонхилон өвддөг бөгөөд хүн халдвар тараадаггүй.

⚠ Халдвар тархах цикл







Онцгой илрэх шинж тэмдэг

- △ Гэнэт цочмог +39-+40 хэм хүртэл халуурах
- △ Чичрүүлэх, даарах
- △ Толгой хүчтэй өвдөх, эргэх
- △ Булчин өвдөх, хөлийн эрээн булчингаар хүчтэй өвдөх, тэмтрэхэд өвдөлт ихсэх
- △ Хэвлийгээр өвдөх, бөөлжих, суулгах
- △ Арьс, нүдний салст шарлах, нүд улайх
- △ Нүүр хүзүү, нүд цэлхийж улайх
- △ Уруул хамрын угалзаар цусархаг цэврүү, хомхой гарах
- △ 3-6 дахь хоногт биеэр улаан тууралт гарах



Хүнд хэлбэрийн үед судасны лугшилт олширч, артерийн даралт буурах ба зүрхний авиа бүдгэрч, цустай цэртэй ханиалга илэрч, амьсгалын дутлын шинж илэрч болно. Элэг дэлүү томорч, бөөрний гэмтлийн шинжүүд давамгайлан, захын тунгалагийн булчирхайнууд почирсон байдаг.

Урьдчилан сэргийлэлт

-  Түүхий ус уух, мал амьтад ордог тогтмол усанд сэлэх, шумбахыг хориглох
-  Мал амьтдыг вакцинжуулах
-  Малчид, малын эмч, мах комбинатын ажилчид, мэрэгчидтэй тэмцэх газрын ажилчдад лептоспирозын амьгүй вакциныг тарих
-  Ажлын хувцас, НБХХ хэрэглэх

Шүлхий (Яшур)

Шүлхий нь өвчтэй амьтнаас хүнд халдварладаг вирусийн хурц халдварт өвчин бөгөөд голдуу салаа туурайтан амьтан өвчилдөг. Хүнд халдварлахдаа өвчтэй малтай шууд хавьтал болсноос, ялангуяа өвчтэй малыг арчлах, өвчтэй малын сүүг хөөрүүлж хэрэглээгүйн улмаас халдварладаг. Салаа туурайтан амьтадын дунд тахал маягтай тархана. Долоон төрлийн вирусээр үүсгэгдэнэ. Вирус нь РНХ агуулсан хамгийн жижиг 10-20 нм хэмжээтэй, гадаад орчиндоо нилээд тэсвэртэй, харин дулаанд амархан үхдэг.

Халдвар авах зам

Өвчний эх уурхай нь өвчтэй адгуусан амьтад. Амьтдаас үхэр, гахай, хонь, ямаа ихэвчлэн өвчлөх ба тэмээ, буга, адуу, илжиг, луус ховор тохиолдолд өвчилдөг. Өвчтэй адгуусан амьтад нь вирусийг шүлс, сүү, өтгөн, шингэнээр ялгаруулна. Хүнд халдварлахдаа шууд хавьтлаар буюу өвчтэй малыг саах, арчлах, эмчлэх, төхөөрөх явцад, сүү, сүүн бүтээгдэхүүнийг сайн болгож хэрэглээгүйгээс, малын хашаа хороо, өтөг бууц, хөрс цэвэрлэх, ноос ноолуур боловсруулах, мал амьсгалах ханиах явцад халдана.



Ялгаснаас хамгийн их аюултай нь шүлс, учир нь их хэмжээний вирустай байдаг. Өвчтэй хүнээс эрүүл хүнд халдварладаггүй. Ямар төрлийн вирусээр үүсгэгдсэн, тэр вирусийн эсрэг дархлаа тогтоно.

⚠ Ямар ерөнхий шинж тэмдэг илрэх вэ?

- △ Гэнэт өндөр халуурах
- △ Толгой, булчин, ууц нуруугаар өвдөх
- △ Хоолонд дургүй болох
- △ Шүлс их хэмжээгээр гоожих
- △ Амны хөндий болон шээсний сүвээр хорсож өвдөх
- △ Нүд улайх

⚠ Өвчний нууц үе 3-8 хоног үргэлжлэх ба эмнэлзүйн хувьд 2 хэлбэртэй.

- △ Амны хэлбэр (Амны хөндийд цэврүүт тууралт гарна)
- △ Арьсны хэлбэр (Биеийн бусад хэсгүүдэд цэврүүт тууралт гарна)



📖 Урьдчилан сэргийлэх арга зам



- 📖 Сүү, сүүн бүтээгдэхүүнийг сайтар буцалгаж хэрэглэх
- 📖 Шүлхийгээр өвчилсөн мал сүрэгтэй харьцаж байгаа хүмүүс хувийн ариун цэврийг сайтар сахих, хамгаалах хувцас хэрэгсэл, амны хаалт, резинэн бээлий, хормогч зэргийг тогтмол хэрэглэх
- 📖 Малын өвчлөл гарсан голомттой нутгаас мал аж ахуйн бүтээгдэхүүн, мах, сүү, малын тэжээл, арьс шир зэргийг тээвэрлэн зөөх, мал тууварлахыг хатуу хориглох
- 📖 Өөрийн эзэмшлийн мал, тэжээвэр амьтадыг мал эмнэлгийн албанаас хийх үзлэг, сэргийлэх тарилга, вакцинжуулалтанд бүрэн хамруулах хэрэгтэй.

⚠ Хачигт энцефалит (Клещевой энцефалит)

Хачигт энцефалит нь флавиовирусээр үүсгэгдэн иксодын төрлийн хачигаар дамжин халдварлаж, төв болон захын мэдрэлийн тогтолцоог сонгомлоор гэмтээн эмнэлзүйн олон хэлбэр илэрдэг байгалийн голомтот вирусийн халдварт өвчин юм. Флавиовирус 25-30 нм хэмжээтэй, дугуй хэлбэртэй РНХ агуулсан уурган бүрхүүлтэй вирус юм. 60С хүртэл халаахад 10 минутын дараа, буцалгахад 2 минутын дараа үхдэг.

⚠ Халдвар дамжих зам

Хачиг нь халдвартай амьтны цус сорсноос 5-6 хоногийн дараа гэхэд вирус хачгийн бүх эрхтэнд нэвтэрч улмаар бэлэг эрхтэн, гэдэс, шүлсний булчирхайд ихээр хурамтлагдан уг амьтныг амьдрах хугацааны /2-4 жил/ турш хүн ба амьтанд халдвар тарааж байдаг. Хүмүүс ихэвчлэн халдвартай хачигт хазуулан халдвар авдаг ба мэрэгч, сүүн тэжээлтэн амьтдаас хоол хүнсний замаар халдвар авч болдог. Халдвартай хачигт хазуулах үед халдвар орсон газраа вирус үржиж-цус-тунгалаг-тунгалагийн булчирхай-дотор эрхтэн-төв мэдрэлийн тогтолцоо-мэдрэлийн эс гэмтэнэ.



⚠ Онцлог шинж тэмдэг

- ⚠ **Хачигт риккетсиоз:** Хачиг хазсан газар 2-3 см бүхий анхдагч үрэвсэл үүсэх, тунгалагийн булчирхай үрэвсэх, бүх биеэр тууралт гарах
- ⚠ **Хачигт боррелиоз:** Хачиг хазсан газар 5 см дээш нүүмэл цагирган тууралт гарах, үе үрэвсэж гэмтэх, захын мэдрэл үрэвсэх
- ⚠ **Хачигт энцефалит:** Хүзүү хөших, үе мөч, ууц нуруу, булчин өвдөх, бөөлжих, уналт саа саажилт, мэнэнгийн шинж илрэх

Хачгийн хөгжлийн мөчлөг

Хачиг нь 2-6 жилийн настай бөгөөд өндөг, авгалдай, нимф, бие гүйцсэн хачиг гэсэн 4 хөгжлийн үе шаттай.



Хачиг нь амьдралынхаа явцад 3 удаа цус сордог



Өндөг



Авгалдай



1 дэх эзэн амьтан

Жижиг амьтад /шуууу, хулгана/



Хүүхэлдэй



2 дах эзэн амьтан

Жижиг хөхтөн амьтад /туулай, буга, хүн/



Бие гүйцсэн хачиг



3 дах эзэн амьтан

Том хөхтөн амьтад /нохой, мал, буга, хүн/

⚠ Ямар үед хачигт хазуулах эрсдэлтэй вэ?

△ Ой модонд: Зугаалах, мод бэлтгэх, жимс, эмийн ургамал түүх

△ Мал, малын ноос, ноолууртай харьцахад: Ямаа самнах, хонь хяргах, ноос ноолуур боловсруулах




⚠ Хачиг хаана шимэгчилдэг вэ?

Хүнд: Хүний нимгэн арьстай хэсэгт шимэгчилнэ.



Хачиг хаана шимэгчилдэг вэ?

Мал, амьтанд:



Хачгийг хэрхэн биеэс салган авах вэ?

Дараах хэрэгслийг ашиглан хачгийг биеэс салган авах боломжтой.



Хачгийг шууд гараараа авч болохгүй!!!

1
Алхам

Нарийн үзүүртэй хямсаа ашиглах



Утас ашиглах



2
Алхам

Хямсаа ашиглан арьстай аль болохоор ойр, хачгийн хошуу, толгой хэсгээс хавчина.



Утсаа хачгийн хошуунд аль болохоор ойр зангидна.



3
Алхам

Удаан, болгоомжтойгоор 45 градусын налуугаар ганхуулан татан авна.



Удаан, болгоомжтойгоор мушгиж татах хөдөлгөөнөөр дээш татаж авна.



4
Алхам

Хачиг хазсан хэсгийг спирт, иодын уусмалаар арчих, эсвэл савантай усаар сайн угаана.



5
Алхам

Салгаж авсан хавчаа битүү уут, саванд хийж шинжилгээнд өгөх эсвэл хогийн саванд хаяна.



Урьдчилан сэргийлэх арга зам

- Хачиг дайжуулагч бодис, тосон түрхлэг хэрэглэх
- Тод өнгийн битүү хувцас өмсөх
- 2-3 цаг тутамд биедээ хачиг байгаа эсэхийг шалгах
- Малын сүүг буцалгаж хэрэглэх
- Хачигт энцефалитаас сэргийлэх вакцинд бүрэн хамрагдах хэрэгтэй.


⚠ Галзуу өвчин

Галзуу өвчин нь вирусээр үүсгэгддэг ба төв мэдрэлийн тогтолцооны гэмтлийг үүсгэж, хөдөлгөөний төвийн сэрэл ихэссэнээр амьсгал, залгих булчингуудын таталт өгч улмаар саажилт болж богино хугацаанд үхлээр төгсдөг халдварт өвчин юм. Халдвар авч өвчилсөн тохиолдолд 100% нас баралтаар төгсдөг.

⚠ **Халдварын эх уурхай:** Байгал дээр вирусийг хадгалагч эх уурхай нь өвчтэй амьтан. Тэжээвэр: Нохой, муур, таван хошуу мал, гахай. Зэрлэг: Чоно, үнэг, хярс, сарьсан багваахай.



Монгол улсад галзуугаар өвчилсөн чоно, үнэг, хярс, нохой, тэмээ, адуу, хонь, ямаа, халдварын эх уурхай болж байна. Галзуу өвчний вирус нь өвчилсөн амьтны шүлсэнд ихээр агуулагддаг ба биеийн аль нэг хэсэгт хазсан, шархны талбайн хэмжээ, шархны гүн, олон цөөнөөс хамаарна. Чоно нь хамгийн хүнд, олон тооны шархлааг үүсгэдэг учир хазуулсан болгон өвчилдөг. Улмаар хүний биед вирус орж мэдрэлийн ширхэгээр дамжин төв мэдрэлийн тогтолцоонд хүрч уураг тархийг гэмтээдэг.



Ямар шинж тэмдэг илэрдэг вэ?

Галзуу өвчний нууц үе нь 12-90 хоног. Цөөн тохиолдолд 1 жил хүртэл үргэлжиж болно. Нууц үеийн хугацаа харилцан адилгүй байгаа нь шархны их, бага, байрлалаас хамаарна.

- △ **Өвчний урьдал үе:** Өвчтөн цочромтгой болох, хазуулсан шархны орчимоор өвдөх, чичрүүдэс хүрэх халуурах, ууц нуруугаар өвдөх, үе үе мэдээ алдах, бие сулрах зэрэг шинжүүд 2-3 хоног үргэлжилнэ.
- △ **Хөөрлийн үе:** Залгих булчингууд таталтын байдалд орсноос болж шингэн юм ууж чадахгүй болох, нүдэнд хий юм харагдах, бүх биеийн хамарсан таталт бий болж өвчтөн орилж, хашгирах
- △ **Саажилтын үе:** Таталтууд, сэтгэл хөөрлийн шинж үгүй болж өвчтөн хөдөлгөөнгүй хэвтэнэ, гар хөл, нүүрний ба өрцний булчингууд саажиж, бүтэлтээс болж өвчтөн нас барна.



Урьдчилан сэргийлэлт

- 📖 Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь амьтан тэжээгч эздээс эхэлдэг
- 📖 Өөрийн амьтнаа вакцинд хамруулснаар иргэн өөрийгөө болон бусдыг хамгаалдаг
- 📖 Зэрлэг болон хараа хяналтгүй амьтнаас сэрэмжлэх
- 📖 Хазуулсан тохиолдолд шархыг нэн даруй савантай усаар сайтар угааж цэвэрлэх
- 📖 Дараа нь 70%-ийн спирт, иод повидон иодын уусмалаар цэвэрлэж, оёдол тавих
- 📖 Галзуугийн эсрэг вакцин, ийлдэс зааврын дагуу хийх буюу 3-6 удаа хийнэ. Галзуу амьтанд хазуулсан дарууд таривал үр дүн илүү. Вакциныг хүйсний эргэн тойронд 5-6 см-ын зайд арьсны доорхи өөхөн эдэд тарина. Вакцины хэмжээ, хугацаа нь шархны хүнд, хөнгөн, байрлалаас болж янз бүр байдаг.

⚠ Ку чичрэг

Ку чичрэг гэдэг өвчин нь янз бүрийн замаар халдварлагдан тархаж халууралт, хордлогын шинж тэмдэг болон олон эрхтэн тогтолцооны гэмтлээр илрэн ужиг явагддаг байгалийн голомтот халдварт өвчин юм.

⚠ **Халдварын эх уурхай:** Өвчний үүсгэгчийг байгалийн голомт дээр 40 төрлийн хачиг, 47 төрлийн зэрлэг шувуу, 60 төрлийн зэрлэг амьтад биедээ агуулна. Байгалийн голомтоос гэрийн тэжээвэр амьтад, тухайлбал бод, бог мал, адуу, тэмээ, нохой, гэрийн шувууд халдвар авдаг. Ку чичрэг өвчин хүнд янз бүрийн замаар буюу хоол хүнс, ус, агаар дусал, ахуйн хавьтал болон гэмтсэн арьс салстаар дамждаг.

⚠ **Ямар шинж тэмдэг илрэх вэ?** Ку чичрэг өвчин үечилсэн явцтай халдварт өвчин бөгөөд цочмог, ужиг, архаг, хэлбэрээр илэрдэг. Өвчний нууц үе 3-32, дунжаар 19-20 хоног үргэлжилдэг. Ихэвчлэн гэнэт дагжин чичрэх, 39-40С хэм хүртэл халуурах, Их хөлрөх, толгой хүчтэй өвдөх, нүдний угаар өвдөх, хамраас цус гарах, Хуурай зовиуртай ханиалгана. Хүнд явцтай бол нойр алдагдах, толгой эргэх, хөөрлийн байдалд орж дэмийрэх, биеэр тууралт гарах, зүрхний цохилт удааширч артерийн даралт буурах, уушгинд хатгаа үүсэх, элэг дэлүү томорч, өтгөн хатна.



📖 Урьдчилан сэргийлэлт


- 📖 Халдвар хамгаалал, ариун цэврийн арга хэмжээнүүдийг авах.
- 📖 Гэрийн тэжээвэр амьтдыг халдвараас хамгаалах зорилгоор малын байрыг тогтмол ариутгаж байх
- 📖 Байгальд голомтлон амьдардаг хачигийг устгах ба аль болох өрөө тасалгаанд оруулахаас хамгаалах
- 📖 Өвөрмөц урьдчилан сэргийлэлт буюу вакцин хийдэг.

⚠ Татран (Столбняк)

Татран өвчин нь татрангийн савханцрын хүчтэй хорын нөлөөгөөр хүний мэдрэлийн тогтолцоог гэмтээж, хөндлөн судалт булчингийн чангарал, чичирхийлсэн таталтыг өгдөг цочмог халдварт өвчин юм.

⚠ **Үүсгэгч:** Татрангийн *Clostridium tetani* (*C.tetani*) нян нь *Clostridium tetani* (*C.tetani*) мал амьтны гэдсэнд үржиж өтгөнөөр гадагшлан газрын хөрсийг (малын бэлчээр, тариалангийн талбай, ялагдсаар бохирлогдсон газар) бохирдуулж байдаг хамгийн тархмал бичил биетэн юм. Татрангийн савханцар нь гадаад орчинд бүрхүүл хуяг үүсгэж, газрын хөрсөнд 100 гаруй жил хадгалагддаг буюу өвчин үүсгэгчийг дамжуулах нөхцөл нь газрын хөрс шороо болдог.

Агаартай гадаад орчинд идэвхгүй хуяг бүрхүүлтэй оршдог. Ингээд хүний гэмтсэн арьс, салстаар (ил шарх, гүн шарх, түлэнхийн шарх, амьтанд хатгуулсан, ялангуяа доод мөчний шархтай байх г.м) нэвтрэн ороод хуягт байдлаасаа ургал хэлбэрт шилжиж халдварын шинжийг үүсгэдэг.




⚠ Ямар шинж тэмдэг илэрдэг вэ?

- ⚠ Өвчний далд үе 1-21 хоног буюу өөрөөр хэлбэл шарх эдгэрсний дараа шинж тэмдэг илэрдэг байна.
- ⚠ Мэдрэл сульдлын хам шинжээр (толгой өвдөх, цочромтгой болох, хөлрөх, шархны хэсэгт булчин шөрмөс татах шинж илэрч) эхэлнэ.

- △ Зажлуурын булчин хөшиж чангарах, амаа ангайхад хөшиж хөндүүлэнэ.
- △ Улмаар нүүрний булчин татах, хүзүү, эрүүний булчин өвдөнө.

! Эхний шинж тэмдгүүд илэрмэгц эмчилгээг эрчимтэй хийх шаардлагатай байдаг.

- △ Цаашлаад нүүрний булчингийн таталтууд улам ихсэхийн зэрэгцээ нуруу мөчдийн булчингийн таталтууд эхэлдэг.
- △ Хүнд тохиолдолд шүд нягт наалдаж ам нээх боломжгүй болно.
- △ Опиостотонус - шинж нь нурууны булчин нумрах маягаар, 2 гарын булчин нугарах хэлбэрээр агшиж бүх биеэр таталт өгнө.
- △ Таталтын давтамж цагт 1-2 удаа 15-30 үргэлжлэнэ.
- △ Маш хүчтэй таталтын үед төвөнх, хавирганы завсрын булчин, өрцний булчингууд агшсанаас амьсгал бүтэж нас барах аюултай.
- △ Өвчний тавилан сайнгүй, 20-25%-д нас баралтаар төгсдөг.




📖 Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

- 📖 Манай улсад хүүхдэд сахуу-татран-хөхүүд ханиадын эсрэг 3-т вакциныг, сахуу-татрангийн 2-т вакциныг тусгай товлолтын дагуу хийдэг бөгөөд, түүнд бүрэн хамрагдах
- 📖 Насанд хүрэгчдэд 10 жилд нэг удаа хийнэ.
- 📖 Анатоксиныг 0.5 мл-ээр 1 сарын завсартайгаар 2 удаа тарина. 9-11 сарын дараа давтан вакцинжуулалтыг хийх ба 5-10 жилийн дараа дээрх тунгаар тарина.
- 📖 Яаралтай урьдчилан сэргийлэх вакциныг, вакцин хийлгээгүй хүмүүст хийдэг, ингэснээр дархлаа тогтоно.

ЗУРГАА. АНХНЫ ТУСЛАМЖ







Зөөлөн эдийн гэмтэл

Зөөлөн эдийн битүү гэмтэл нь мал, амьтантай харьцдаг хүмүүст хамгийн элбэг тохиолддог гэмтэл юм. Зөөлөн эдийн гэмтэл нь унаж бэртэх, мохоо иртэй зүйлээр цохигдох, биеийн хүчний ажил хийх явцад хүний булчин, үеийн холбоос, шөрмөс гэмтэхийг хэлнэ. Зөөлөн эдийн битүү гэмтэлд зөөлөн эдийн няцралт, суналт, тасралт, дарагдалт багтана.

 **Няцралт нь** хэсэг газрын арьсан доорхи өөхөн эд, хялгасан судаснууд хагарч гэмтсэнээс цус хурж, хаван, хавдалт үүсэхийг хэлнэ. Няцралт үүссэн газарт өвдөлттэй, цус хурж, овойж хавдсан гарын алгаар дарж үзэхэд чинэрч халуун оригсон, лугшилт үүссэн байдаг. Үенд таарсан байвал үений завсар шингэн хуримтлагдсанаас хөдөлгөөн хязгаарлагдана.



Яаралтай авах арга хэмжээ

-  Өвчтөнийг тайвшруулна.
-  Давстай ус, хүйтэн цайгаар даралттай боолт хийнэ.
-  Гарт үүссэн бол гарыг цээжинд байрлуулан боолт хийж, хүзүүнээс сойно.
-  Хөлд үүссэн бол хэвтүүлж биенээс дээш 30-40 см-г байрлахаар тооцож, хэсэг газарт боолт хийнэ.
-  Хүйтэн жин, мөс тавина.
-  Хэрэв огт хөдөлж чадахгүй, өвдөлт их байвал хугарал байж магадгүй тул эмчид хандах хэрэгтэй.

⚠ Зөөлөн эдийн суналт нь үе, үеийн уут, шөрмөсөнд үүсдэг ба ихэвчлэн шагайн үенд, бугуйн үе холбоосоор, унах үедээ гараар тулж унах үед үүсдэг. Илрэх шинж тэмдэг нь маш хүчтэй өвдөлт, хөдөлгөөн, үйл ажиллагаа бүрэн хязгаарлагдаж тусламж эрсэн байдалтай байх ба зөөлөн эдэд цус хурж, хавдаж овойсон байдалтай байна.




Яаралтай авах арга хэмжээ

- 📖 Тухайн өвчтөнг хэвтүүлж, тайвшруулна.
- 📖 Хөдөлгөөнгүй байхыг зөвлөнө.
- 📖 Боолт сойлт хийж өгнө.
- 📖 Өвдөлт намдаах журмаар хүйтэн жин, мөс тавина.
- 📖 Эмнэлэгт хүргэнэ.




Боолт хийх дараалал

1




2




3




4



5




6



⚠ Булчин ба шөрмөс тасрах нь өндрөөс унах, хүнд зүйл өргөх, гэнэт огцом хөдөлгөөн хийж булчин агшсанаас үүсдэг. Булчин тасрах үед маш их өвдөлт мэдрэгдэнэ, дуу гарна, тасарсан хэсгээр эхэндээ хонхойж харагдана, булчин агшихад тасархайтан агшина, цус хурж хавдана.



⚠ Шөрмөс тасрах үед: Тасарсан хэсэгт их өвдөлттэй, хөдөлгөөн хийхэд өвдөлт ихсэнэ, тасарсан хэсэг тэмтрэгдэж, хонхойж харагдана, мөчдийн хуруунуудын хөдөлгөөн бүрэн алдагдана, хуруунууд тэнийсэн эсвэл нугаларсан байрлалд байна.




Яаралтай авах арга хэмжээ

- 📖 Өвчин намдаах зорилгоор эм уулгана.
- 📖 Хүйтэн жин, мөс тавина.
- 📖 Хөдөлгөөн хязгаарлаж чиг тавьж, боолт хийнэ.
- 📖 Энэ үед гэмтлийн болон мэс засалч эмч нар үзэж онош тавин, эмчилгээг эхлэх учраас заавал эмнэлэгт хүргэж өгнө.







Ясны хугарал

Аливаа ясны хугарал нь маш эрчтэй хүчний (зам тээврийн осол, өндрөөс унах, хүчтэй цохилтод, буудагдах, эрчтэй шидэгдэх) үйлчлэлээр болон байнгын ясны хэт ачаалал (стресс, ядаргааны шалтгаант) зэрэг гэмтлийн болон эмгэг өвчний шалтгаантай үүсдэг. Ясны хугарал ойр орчмын судас, мэдрэлийн ширхэг, булчин, эд эрхтэний гэмтэлтэй хавсран тохиолддог. Ясны хугарлыг эмгэг байдлаар нь ил болон далд хугарал гэж ангилна.

 **Ил хугарал гэдэг нь** ясны хугарсан хэсэг гадна орчинтой шууд харьцсан байхыг хэлдэг. Шинж тэмдэг нь гэмтлийн улмаас хөлийг тэжээж байдаг судас, мэдрэлийн судлууд гэмтэж, өвдөлт улам ихсэж хөдөлгөж чадахгүй болно. Маш их өвдөлттэй, хугарал ил харагдана, ил шархнаас цус алдана, ойр орчиндоо хавдсан, мөчдийг бүтнээр харахад нэг тийш муруйсан байна. Ил хугарлын үед шарханд хүрэхийг хориглоно.



Ил хугарлын үед ямар арга хэмжээ авах вэ

-  Гэмтсэн хүнийг эхлээд тайвшруулна.
-  Тухайн газарт нь хөдөлгөөнгүй, тухтай байлгах нөхцөлийг бүрдүүлнэ.
-  Шархыг иод, спиртын уусмалаар цэвэрлэж, тухайн хэсэгт цэвэр марлийг нугалж тавиад уян боолт хийнэ. Боолт хийснээр цус тогтоно.
-  Цус тогтохгүй бол цус тогтоох бусад аргаас хэрэглэнэ.
-  Чиг тавьж бооно.
-  Эмнэлэгт яаралтай хүргэнэ.

⚠ Далд хугарлын шинж тэмдэг: Далд хугарал нь ясны бат бөх чанараас давсан механик хүчний нөлөөлөлд үүсдэг. Их өвдөлттэй, ихэвчлэн нэг байрлалд хөдөлгөөнгүй, явж чадахгүй, айж сандарсан байдалтай, хугарсан хэсэгт хавдсан, тухайн мөч бүдүүрч өргөссөн байх, хавдсан хэсгийн арьсан дор цус хуралт үүсч хөх ягаан улаан хүрэн өнгөтэй болно, нүдэнд харагдахуйц мөч хэлбэр алдагдсан байдаг, битүү хугарлын хэсгийг барьж үзэхэд хяхрах чимээ гарна, гараа тавьж үзэхэд халуун оргисон, хувцасыг тайлж, мөчдийг бүтнээр харахад аль нэг тийш муруйсан байдаг.



Далд хугарлын үед ямар арга хэмжээ авах вэ

- 📖 Тухайн газарт нь хөдөлгөөнгүй, тухтай байлгах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 📖 Гэмтсэн хэсгийн гаднах арьсийг цэвэрлээд дахин ямар нэг шарх шалбархай байгаа эсэхийг хар, байвал ил гэмтлийн адил тусламж үзүүлнэ.
- 📖 Хэрвээ шарх шалбархай байхгүй бол тухайн шилбэний урт болон өргөнд нийцэх чигийг тухайн мөчний урттай хэмжээтэй тавина.
- 📖 Хамгийн ойрын эмнэлэгт хүргэнэ.



Чиг тавьж боолт хийх арга: Чиг тавихын гол зорилго нь мөчдийг хөдөлгөөнгүй байлгахад оршино.

- 📖 Чиг тавих зүйлийг гарын доорхи материалыг ашиглана. Үүнд баглаж боодог уяа, дээс, хувцас, боолт, алчуур г.м
- 📖 Тухайн мөчинд тохирсон чиг бэлтгэнэ.
- 📖 Чигээ тухайн мөчинд бэхлэн барьж бинт, даавуугаар бооно.
- 📖 Чигийн дотор талд холгохоос сэргийлж зөөлөвч хийхээ мартав.
- 📖 Чигийг хэт чанга боохоос сэргийлнэ.
- 📖 Боолт хийсэн дараа мөчдийн үзүүр бүлээн байна уу, өнгө нь биеийн бусад хэсэгтэй адилхан байгаа эсэхийг шалгана.

⚠ Эгэмний хугарал байвал яаж таних вэ?



Насанд хүрэгчдийн эгэм голдуу хөндлөн, ташуу бяцарч хугараад зөрдөг бол хүүхдийнх хальсныхаа дотор голдуу хөндлөн хугараад нойтон бургас шиг тахийдаг байна.



⚠ Илрэх шинж тэмдэг: Хугарсан талын мөр бага зэрэг унждаг, эрүүл талаас урагш байрлалд орсон, эрүүл гараараа гэмтсэн талын тохой, шууг биедээ шахаж барьсан байх, гэмтсэн талруугаа толгой гэлжийсэн байрлалтай байх, гэмтсэн талын бугалга урт юм шиг харагдана.

⚠ Барьж, дарж үзэхэд хөндүүрлэнэ, доод талын хугархай үзүүр овойж, шовойж мэдэгдэнэ, мөрийг хөдөлгөж үзэхэд хэвийн хөдөлгөөнтэй боловч эгэмний хугарлын төвшинд өвдөлт өгнө, заримдаа яс хавирч, хугарлын орчимд хөдөлж мэдэгдэнэ.


Эгэмний хугарлын үед хийх боолтын байдал



⚠ Мөрний үеийн мултралыг яаж таних вэ?

Мөрөөрөө шууд болон гараар хүчтэй тулж унах үед мушгирах хөдөлгөөнтэй хавсрахад атгаал чөмөгний толгой далны хонхороос мултрахыг мөрний мултралт гэдэг. Мөрний мултрал нь урагш болон хойшоо мултралт гэж байдаг.

Зүүн гар талаас мөрний үеийн хэвийн байдал, урагш, хойш мултарсан байдал




⚠ Шинж тэмдэг: Өвдөлттэй, гарыг хөдөлгөхөд өвдөлт нэмэгддэг, мөрний үеийн хөдөлгөөн хязгаарлагдана, мултарсан талын гарыг эрүүл гараар дэмжиж барих, мөр мултарсан тал руу өвчтөн хазайсан байрлалд орно, мөр хавтгай, өнгөц үүсгэсэн байна.



Анхны тусламж

- 📖 Өвчтөнг суулгана. Мултарсан талын гарыг зөөлөн цээжинд нугалж бариулна. Ингэснээр өвдөлт буурна.
- 📖 Гурвалжин алчуурыг цээж болон гэмтсэн мөчний хооронд байрлуулж сойлт хийхэд бэлтгэнэ.
- 📖 Гэмтсэн гар болон цээжний хооронд зөөлөн жийргэвч байрлуулна.
- 📖 Гурвалжин алчуурыг биед эвтэйхнээр уяж, сойлтыг хийнэ.
- 📖 Өвчтөнг эмнэлэгт хүргэнэ.


Мултарсан мөрний үеийг хэвийн байдал оруулж болох аргууд



⚠ Бугалганы хугарлыг яаж таних вэ?


Бугалга буюу атгаал ясыг 3 хэсэгт хуваадаг. Дээд булуу нь мөрний үеийг үүсгэдэг, дунд хэсэг нь ганган хэсэг, доод булуу нь тохойн үеийг үүсгэж байдаг. Голдуу тохойлдож унах, механик зүйлээр хүчтэй цохих, машинд шүргүүлэх, мөргүүлэх үед хугарал үүсдэг.

⚠ Таних шинж тэмдэг: Өвдөлттэй, хэлбэр дүрс алдагдаж хавдсан, хөдөлгөөн хийхэд илүү өвдөх, ялангуяа ганган хэсгээр нугарах хөдөлгөөн ажиглагдах, гарыг хөдөлгөж чадахгүй, үйл ажиллагаа нь алдагдсан байна. Чиг тавьж боох байдал:








⚠ Шууны хугарлыг яаж таних вэ?

Шууны яс 2 хэсгээс бүрддэг бөгөөд дангаараа болон хавсарч хугардаг. Гарыг тулж унах, унахдаа мушгирч унах, янз бүрийн зүйлээс өөрийгөө хамгаалах үйлдлээс бамбай болгосноос цохигдсон үед голдуу хугардаг байна.



⚠ Таних шинж тэмдэг: Өвдөлттэй, хэлбэр дүрсээ алдаж, хавдсан байх, хөдөлгөөн хийхэд өвдөлт нэмэгдэнэ, гарыг хөдөлгөж чадахгүй, үйл ажиллагаа алдагдана.

 **Анхны тусламж**

-  Өвчтөнийг тайван суулгаад гэмтсэн гарыг зөөлнөөр цээжинд нь нугалан бариулна.
-  Гурвалжин алчуурыг цээж болон гэмтсэн мөчний хооронд байрлуулан сойлт хийхэд бэлтгэнэ.
-  Гэмтсэн шуу болон цээжний хооронд зөөлөн жийрэг байрлуулна.
-  Гурвалжин алчуурыг биед эвтэйхнээр уяж, сойлтыг хийнэ.
-  Өвчтөнг эмнэлэгт хүргэхдээ суугаа байрлалд авч явна.

Шууны ясны хугарлын үед гарын доорхи материал ашиглан чиг тавьж боосон байдлууд



 **Алга болон хурууны үеийн хугарлыг яаж таних вэ?**

Хурууны хугарлыг ихэвчлэх хар цайгаар шавшаад өнгөрөх тал ажиглагддаг. Гар сарвуу нь хялгасан судас ихтэй эрхтэн учраас судас гэмтэн цус хурах, цаашлаад идээлж буглах, үйл ажиллагаа нь алдагдахад хүрдэг.


Гарын сарвууны далд хугарал



Хурууны хугарал гаднаас харагдах байдал



Сарвуу болон хурууны үеийн хугарлын үед хийх боолтууд



⚠ Цээжний гэмтлийн үед авах арга хэмжээ

Цээжний хэнхэрцэг, хавирга гэмтэхэд хүний амин чухал эд эрхтнүүдийг гэмтээх аюултай байдаг. Цээжний гэмтлүүдийг илэрч буй байдлаар нь цээжний битүү гэмтэл, цээжний ил гэмтэл буюу шархдах гэж ангилдаг.

⚠ Цээжний битүү гэмтлийн үеийн шинж тэмдэг


Амьсгалахад хүндрэлтэй, өнгөц амьсгална, цээжээр өвдөлт ихтэй, гүн амьсгал авахад хүчтэй өвдөнө, арьс цайж, уруул хөхөрсөн, гар хөлд хүрэхэд хүйтэн болсон, хавирганы хугарлаас ил шарх үүссэн бол амьсгалах үед агаар цээжний хөндийд сорогдон орох чимээ гарна, хэрэв уушги гэмтсэн бол ханиалгах ба цустай цэр гарах, эсвэл амнаас цус гарах болно.



Яаралтай үзүүлэх тусламж

- Өвчтөнг аль болох тайван байлгаж, хагас суугаа байрлалд байлгана.
- Өвчтөнг яаралтай эмнэлэгт хүргэнэ.

Цээжний боолт хийх, тээвэрлэх байрлал



Цээжний ил гэмтлийн үеийн шинж тэмдэг

Шарх гүн байвал амьсгал давчдана, нээлттэй шархаар цус алдана, өнгөц гэмтлийн үед зөөлөн эд хавагнаж орчинд цус хурна, амьсгал авах, гаргах үед өвдөлт ихэснэ.



Яаралтай үзүүлэх тусламж

- Өвчтөнг хагас суугаа байрлалд байлгана
- Цээжний ил шархыг цэвэр материалаар боолт хийх буюу болж өгвөл ус нэвтрэхгүй материалаар (ахуйн гялгар уут байж болно) бүрж халхална.
- Яаралтай түргэн тусламж дуудах ба эмнэлэгт хүргэнэ.

⚠ Аарцаг буюу тааз ясны хугарлыг яаж таних вэ?

Аарцаг ясны гэмтэл нь авто машины осол, өндрөөс унах, маш хүчтэй цохилт, элдэв зүйлд дарагдах, хавчуулагдахад үүсдэг. Аарцагны гэмтлийн үед дотор эрхтнүүдийн гэмтэл хавсарч тохиолддог тул сайтар шалгах хэрэгтэй байдаг.


⚠ Таних шинж тэмдэг: Өвчтөний аарцаг, цавь, салтаа, нуруугаар өвдөлт ихтэй байна, ташааны дэлбэн дээр дарахад өвдөлт нэмэгдэнэ, гэмтсэн талын хөл гадагш эргэнэ, ямар ч шалтгаангүйгээр шээмээр санагдана, дотуур цус алдана, амьсгал, зүрх судасны үйл ажиллагаа алдагдана, хөдөлгөөн эрс хязгаарлагдсан байх, шоконд орж болно.



Чиг тавьж боох аргууд болон энэ үед анхаарах санамж

- ☞ Өвчтөнийг хөдөлгөж, босгож, савлаж болохгүй, байгаа газарт нь хөдөлгөөнгүй хэвтүүлнэ.
- ☞ Цусны эргэлт, судасны цохилт, хялгасан судасны дүүрэлт, мэдрэлийн үйл ажиллагааг шалгаж үнэлнэ.
- ☞ Өвчтөнг тээврийн зөв байрлалд байрлуулна.
- ☞ Аарцагны ясны хугарлын үед аарцагны хэлбэр алдагдах, хугарлын хурц өвдөлт өгдөг учраас ясны болон эд эрхтэний хөдөлгөөнийг багасгах зорилгоор аарцаг хэсгээр чангалсан битүү боолт хийж өгнө.
- ☞ Мэлхий хэлбэрийн байрлалд оруулж хэвтүүлнэ.
- ☞ Хоёр хөлийг салгаж, түнхний үе, өвдөгний үеэр хагас нугалж тахимны дор ивээс хийнэ.
- ☞ Хүзүүний үеийг хөдөлгөөнгүй болгож, хүзүүн дор таарсан эвээс хийж, болж өгвөл толгойг хөдлөхгүй байх бэхэлгээг хийнэ.

Аарцагны ясны гэмтэлтэй хүнийг тээвэрлэхэд бэлтгэсэн байдал




⚠ Дунд чөмөгний ясны хугарлыг таних шинж тэмдэг

Дунд чөмөгний ясны хугарал нь хүнд гэмтэлд ордог ба их хэмжээний цус алдаж шоконд орох аюултай байдаг. Дунд чөмөгний хүзүү хэсгийн хугарлын үед мэс заслын эмчилгээ хийгдэж, хөдөлмөрийн чадварыг удаан хугацаагаар алдагдуулдаг. Дунд чөмөгний хугарал нь унах, автомашины осол, хүчтэй цохиолтын үед илүү гэмтдэг. Хугарлын хэлбэрээс хамааран гэмтэл нь хүндрэлгүй, эсвэл хоёрдогч хүндрэл болох цус алдалт, өвдөлтийн шок, өөхөн эдийн бөглөрөл, шархны бохирдолт болон ясны идээт үрэвслүүдийг үүсгэдэг. Дунд чөмөг нь ихэвчлэн хүзүүн болон их бие хэсгээрээ хугардаг.

⚠ Илрэх шинж тэмдэг: Маш хүчтэй өвдөж, хавдана. Гэмтэл авснаас хойш хэсэг хугацааны дараа, гэмтсэн хэсгийн арьсан доорх цус хуралт илэрнэ. Гараар дарж үзэхэд лугшилт мэдрэгдэх ба энэ нь цус алдалт байгааг илтгэнэ. Гэмтсэн талын хөлийн өвдөг, тавхай гадагш унжиж, гэмтсэн хөлийн булчин чангарснаас эрүүл хөлөөс богиноссон байна.

Дунд чөмөгний далд хугарал





Яаралтай авах арга хэмжээ

- 📖 Цус алдалтыг зогсоох боолт тавина.
- 📖 Маш их өвдөлттэй тул өвчин намдаах эм уулгана.
- 📖 Гэмтсэн хөлийг аль болох шулуун байрлалд зөөлөн оруулж туслах хүнээр бариулна.
- 📖 Гарын доорхи материалаар чиг барьж бооно.
- 📖 Өвчтөнг хөдөлгөөнгүй болгож эмнэлэгт хүргэнэ.
- 📖 Шокын байдалд орохоос сэргийлж өвчтөнг дулаан байлгаж, хөлийг өндөрлөнө.
- 📖 Тээвэрлэхдээ өвчтэй хөлийг эрүүл хөлд бэхлэн чиг тавина.
- 📖 Эмнэлэгт хүргэх буюу түргэн дуудна.



Чиг тавьж боохдоо дараах зүйлийг анхаарна


- 📖 Дунд чөмөгний хугарлын үед 3 үеийг хамруулан чиг тавих учраас 3 ширхэг урт чиглүүлэгч бэлдэнэ.
- 📖 1-р чиглүүлэгчийг гэмтсэн талын суганаас шагай хүртэл, 2-р чиглүүлэгчийг салтаанаас шагай хүртэл, 3-р чиглүүлэгчийг нуруун дор шагай хүртэл тавина.
- 📖 4-5 см өргөнтэй эвхсэн уяагаа шагай, өвдөг, цавь, ташаа, хэвлий, цээжний дээгүүр болон доогуур уяж хөдөлгөөнгүй боолт хийнэ.
- 📖 Салтаа, шагай, өвдөг, суганд зөөлөвч тавина.
- 📖 усламж үзүүлсэн цагаа боолтон дээр бичих ба хэвтээ байрлалд дамнуурган дээр хэвтүүлж, нэн даруй эмнэлэгт хүргэнэ.



Шилбэний ясны хугарлыг яаж таних вэ?

Шилбэний яс нь өвдөг, шагайн үеийг холбож байрласан 2 урт яснаас бүрддэг ба тахилзуур, шаант гэж нэрлэдэг байна. Энэ 2 яс холбогч эдэн хальсаар холбогдсон холбоотой байх буюу ил хугарал ихэвчлэн тохиолддог байна. Шилбэний ясны хугарал 2 янзаар үүсдэг.


- ⚠ Сул хүчээр үүсэх нь явганаас унаж гэмтэх,
- ⚠ Өндөр хүчээр үүсэх нь хөдөлгөөнт хэрэгслээс гэмтэх, бууны шарх зэргийг хамруулна.



⚠ Шагайн ба тавхайн ясны хугарлыг яаж таних вэ?

Шагай болон хөлний орчим өвдөг хүртэл дамжиж өвдөнө, шагайн үеэр хавдана, хөхөрч хавддаг, гишгэж чадахгүй, шагайн орчмын ясны хэлбэр дүрс алдагдана. Хугарсан шинж ажиглагдвал хөдөлгөөнийг багасгах зорилгоор чиг тавьж бооно.

Шагайн үеийн гэмтэл, мултралын үед хийх боолт




⚠ Нурууны гэмтлийн үед авах арга хэмжээ

Хүний нуруу нь нугас, холбогч эдийн үе, булчин, нугалмын хэсгүүдээс бүрдэх цогц бүтэц юм. Нурууны аливаа гэмтэл нь эрүүл мэндийн ноцтой нөхцөл байдлыг үүсгэдэг. Дараах тохиолдолд нуруу гэмтэж болзошгүй. Үүнд:

- ⚠ Морь, тэмээтэй явах үед хүчтэй, эвгүй унах, шидэгдэх
- ⚠ Өндрөөс унах (саравч, хороо, байшин, машин г.м)
- ⚠ Зам тээврийн ослын улмаас үүсэх механик нөлөөллөөс
- ⚠ Хүнд зүйлд дарагдах, юманд шахагдах, хүчтэй түлхэгдэх үед
- ⚠ Хүчтэй цохилтын үед
- ⚠ Бусад ясны өвчин эмгэгийн үед.

Нурууны хугарлын байдал



⚠ Нурууны гэмтлийн үед илрэх шинж тэмдэг

Гэмтлийн үед илрэх шинж тэмдэг нь гэмтлийн байрлал, төрлөөс ялгаатай байдаг. Ер нь нурууны гэмтэл хүнд гэмтэл буюу амь насанд аюултай байдаг.


Ерөнхий шинж байдал

- △ Гэмтсэн хэсгийн зөөлөн эдэд хүчтэй өвдөлттэй байх ба биеийг эргүүлэх үед өвдөлт улам ихэснэ.
- △ Гэмтлийн хэсгийн арьсан дор цус хуралт үүснэ.
- △ Гэмтлийн хэсгээс дээш арьсан дор хавдаж, товойсон байна.
- △ Биеийн хөдөлгөөн эрс хязгаарлагдсан байна.
- △ Өвчтөн хөлөө өргөж чадахгүй байна.
- △ Нурууны булчин эрс чангарсан байна.
- △ Нуруу нугасны гэмтлийг тодорхойлохдоо хөдөлгөөний болон мэдрэхүйн ажиллагааг хөнгөн шалгаж болно (хөнгөн чимхэх, хатгаж үзэх, гар хөлийг хөдөлгөж үзэх гэх мэт).









Яаралтай авах арга хэмжээ

- 📖 Түргэн дуудах ба өвчтөнтэй маш болгоомжтой харьцах
- 📖 Нурууны гэмтэлтэйг мэдсэн тохиолдолд өвчтөнг суулгах, босгох, нурууны байрлалыг дураараа өөрчлөх, эргүүлэх үйлдэл хийж болохгүй
- 📖 Заавал 2-3 хамтрагчтай тусламж үзүүлэх
- 📖 Зөөх тээвэрлэхдээ заавал хатуу, хавтгай тавцан дээр хэтээгээр байрлуулах
- 📖 Өвчтөнг шилжүүлэх шаардлагатай үед хэд хэдэн хүний тусламжтайгаар хийх ба хүзүүний хэсгийг бэхлэхэд онцгой анхаарах
- 📖 Өвчтөний амьсгал, зүрх судасны эрхтэний үйл ажиллагааг хянаж байх ёстой ба шаардлагатай тохиолдолд амьдруулах тусламжийг үзүүлэх
- 📖 Тээвэрлэлтийн үед өвчтөнг гулсалт, савах байдлаас сэргийлж, хэвтүүлсэн хатуу тавцантай уяж бэхлэх
- 📖 Нурууны болон хүзүүний гэмтлийн үед заавал хөдөлгөөнгүй болгох бэхэлгээ боолт хийх.



⚠ Түлэгдэлт

Түлэгдэлт нь галын дөл, халуун, шингэн, уур хүчил шүлт зэрэг химийн бодис, цахилгаан гүйдлийн үйлчлэл гэх мэт олон шалтгаанаас үүснэ. Том хэмжээний түлэгдэлтийн үед өвчтөн эмнэлгийн тусламж авахгүй бол халдвар авах болон шингэн алдсанаас үхэлд хүргэх аюултай. Гол төлөв эмэгтэйчүүд, хүүхдүүд түлэгдэх нь элбэг байдаг.

<p>1 зэргийн түлэгдэлтийн үед түлэгдсэн хэсэг улайж, хавдах, хорсох шинж илэрнэ.</p>		
<p>2 зэргийн түлэгдэлтийн үед дээрх шинж тэмдэг даамжирч, тунгалаг шингэнтэй цэврүү үүсдэг.</p>		
<p>3, 4 дүгээр зэргийн түлэгдэлтийн үед арьс төдийгүй булчин шөрмөс түлэгдэж, үхжил үүснэ.</p>		

Түлэгдэлтийн хүнд хэлбэр, их хэмжээний түлэгдэлтийн үед өвдөлтийн шоконд орох, хордлого үүсэх аюултай байдаг.



Жижиг түлэгдэлтэнд үзүүлэх анхны тусламж

- 📖 Өвчтөнөө аюултай газраас холдуулна.
- 📖 Түлэгдсэн хэсгийг гоожиж байгаа хүйтэн усан доор наад зах нь 10-15 минут байлгана.
- 📖 Өвчтөнийг тайвшруулж, сэтгэл санааг нь амраана.
- 📖 Бие барьсан хувцас, бөгж, цагийг хавдалт эхлэхээс өмнө тайлна.

- 📖 Буцалж байсан шингэн буюу химийн бодис нэвтэрсэн хувцсыг урж тайрч хаяна.
- 📖 Хэрэв хүний хувцас, үс зэрэг нь шатаж байвал даруй унтраах арга хэмжээ авна.

👤 Хэрэв түлэгдэл том, талбай ихтэй байвал дор дурьдсан зааврыг мөрд.

- 📖 Өвчтөнийг дамнуурга дээр хэвтүүлнэ.
- 📖 Түлэгдсэн хэсгийг цэвэр даавуугаар бүтээнэ.
- 📖 Өвчтөнд ус бага багаар ойр ойрхон уулгана.

⚠️ Түлэгдсэн хүнд тусламж үзүүлж байхдаа юуг анхаарах хэрэгтэй вэ?

- ⚠️ Түлэгдсэн хэсэгт наалдсан ямар ч зүйлийг хуулж авч болохгүй.
- ⚠️ Түлэгдсэн хэсэгт ямар ч өөх тосны зүйл түрхэж болохгүй.
- ⚠️ Түлэгдсэн хэсэг дээр шууд хөвөн тавьж болохгүй.
- ⚠️ Шархны лентээр боолт хийж болохгүй.
- ⚠️ Түлэгдэлтээс үүссэн цэврүүг хагалж болохгүй.

⚠️ Аюултайн шинж тэмдэг:

Их хэмжээний түлэгдэлтэй бол түлэгдсэнээс хойш 12 цагийн дараа аюулын шинж тэмдэг илэрнэ. Үүнд:









- ⚠️ Халуурах
- ⚠️ Арьснаас үнэр гарах
- ⚠️ Түлэгдсэн хэсгээс идээ гарах
- ⚠️ Бие нь суларч нойрмоглох, ухаан нь орж гарах, эсвэл ухаан алдах.



Шархны халдвар

Шарх гэдэг нь механик хүчний нөлөөгөөр арьс, арьсан доорхи эд эрхтэн, судас гэмтэхийг хэлдэг. Арьсны шарх нь зүсэгдэх, хатгагдах, цавчигдах, хазагдах, няцралт, урагдал, буудагдсан зэргээс үүсдэг. Гэвч шархадсан үедээ цусыг тогтоон, боолт хийж шархыг бүр эдгээхгүй орхидог дутагдал манай малчдад элбэг байдаг. Тэгвэл дутуу эдгэсэн буюу нээлттэй шарханд нян бактер үржиж улмаар бие махбодиор халдвар тархан татрангийн халдварыг үүсгэх аюултай (татран өвчнөөс харна уу).

Шарх үүссэн үед авах арга хэмжээ

-  Өвдөлтийг намдаах эм ууна.
-  Хэрэв шороо орж янз бүрийн зүйлээр бохирдсон бол савантай бүлээн усаар сайтар угаана.
-  Шархны эргэн тойронг иод болон спиртын төрлийн ариутгагч бодис шингээсэн бинт, ариун зүйлээр төвөөс нь гадагш нь чиглэлээр арчиж, хиргүй болтол 2-4 удаа арчина.
-  Спирт, иод шингээсэн бинт тавьж, боолт хийж өгнө.
-  Хэрэв аль нь ч байхгүй тохиолдолд нойтон цаасан салфетек, цэвэр нусны алчуур зэргээр чангахан боогоод хамгийн ойр эмнэлэгт очно
-  Хөнгөн гэмтэл, шарх авсан үед аль болох эмнэлгийн тусламж авахыг хичээгээрэй.
-  Шарх үүссэн үед заавал татрангийн вакцин хийлгэх шаардлагатай. Энэ нь шархыг идээлүүлэх, ясны үрэвсэл болж хүндрэхээс сэргийлнэ.
-  Шархыг шууд улаан гараар дарах, оролдож бохир оруулахаас зайлсхийх хэрэгтэй.



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол ном

1. Дагвадорж Я. “Халдварт өвчин”. Их, дээд сургуулийн сурах бичиг. –УБ: 2003. 184х. 11.5х.х.
2. Нансалмаа Ш. ба бусад. “Осол гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж”. Хоёрдугаар хэвлэл. –УБ: ГССҮТ. 2007. 102х. 3.25х.х.
3. Самбуу Ж. “Малчдад өгөх зөвлөгөө”. –УБ: Д.Сүхбаатарын нэрэмжит Улсын хэвлэлийн газар. Мал аж ахуйн яамны хэвлэл. 1956. 277х. 19.75х.х.
4. Самбуу Ж. “Малчин ардын амьдрал ахуй, хэв заншлаас”. –УБ: Д.Сүхбаатарын нэрэмжит Улсын хэвлэлийн комбинат. 1971. 101х. 3.25х.х.
5. Үнэнбат Г. ба бусад. “Анхны тусламжийн лавлах”. –УБ: “Адмон принт” ХХК. 2018. 165х. 10.31х.х.

Орос ном

1. Венгеров Ю.Я. и др. “Инфекционные и паразитарные болезни”. – М.: МедПресс-Информ, 2014. – 472 с.
2. Покровский В.И. и др. “Инфекционные болезни и эпидемиология”. Учебник / - 2-е изд. – М.: ГЭОТАР –Медиа, 2007. – 816 с.
3. Сидоренко С.М. и др. “Первая доврачебная неотложная помощь”. ФГОУ ВПО «Кубанский государственный аграрный университет». – Краснодар.: 2009. – 117 с.

Стандарт

1. MNS 6264:2018 “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага”.
2. MNS OHSAS 18001:2012 “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ба шаардлага”.

Хууль, тогтоомж

1. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 269 дүгээр тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”.
2. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолоор батлагдсан “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай”.
3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/370 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хөтөлбөр”.

Веб сайт:

1. <https://nema.gov.mn/>
2. <http://www.ontsgoisur.gov.mn/>
3. <http://www.tsag-agaar.gov.mn/>
4. <https://safetylinelneworker.com/>
5. <https://www.ccohs.ca/>
6. <http://www.ndaatgal.mn/v1/>